

**“ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ”
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР

2023

ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, СОНГОХ ҮНДЭСЛЭЛ	6
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	7
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	7
2.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	9
2.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	11
2.4. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	15
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	16
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ	17
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	17
3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	25
3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	30
3.4. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	50
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	53
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	57
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	65
ХАВСРАЛТ 1. Хуулийн төслийг бүхэлд нь уншаад өгсөн санал	67

Судалгааны захиалагч: Хууль зүй, Дотоод хэргийн яам

Судалгааны санхүүжүүлэгч: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг (GIZ)

Судалгааны багийн гишүүд:

Багийн ахлагч - Г.Цагаанбаяр /Хуульч, судлаач/

Багийн гишүүн - Э.Энэбиш /Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах
шатны шүүхийн шүүгч/

Багийн гишүүн - Б.Гончигсумлаа /Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч/

Багийн гишүүн - С.Батбаяр /МУИС-Хууль зүйн сургуулийн багш/

Багийн гишүүн - О.Буян-Ундрах /МУИС-ХЗС-ийн 5 дугаар түвшний оюутан/

Талархал

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхэд ярилцлагын судалгаанд оролцож үнэтэй санал, зөвлөмж өгсөн Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар болон өмгөөлөгч нарт талархал илэрхийлье.

Мөн тус судалгааг санхүүжүүлсэн Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн хамт олон судалгааны багийн зүгээс талархал илэрхийлье.

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг сонгон үнэлэх	7
Хүснэгт 2. Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг сонгон үнэлэх.....	9
Хүснэгт 3. Хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг сонгон үнэлэх.....	11
Хүснэгт 4. Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг сонгон үнэлэх	15
Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлт ба шалгах хэрэгсэл	17

“ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад “Энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх” гэж заасны дагуу тус хуулийн төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв. Үүнд:

Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгох;

Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;

Гурав. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж өгөх болно.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийсэн хуулийн төслийг энэхүү тайланд хавсаргав.

¹ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн.

² Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, СОНГОХ ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний судалгааг гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Практикт хэрэглэх боломж;
5. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтыг сонгож авсан болно.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект болох Иргэний хэргийн шүүхийн шүүгч, өмгөөлөгч нараас ярилцлага хийх замаар санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгаж дүгнэлт өгнө.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект болох шүүгч, өмгөөлөгч нараас санал авах, ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг судлана.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцдог тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие даасан үнэлгээгээр тооцох болно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх бөгөөд хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр сонгов.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд дагаж мөрдөх болон хэрэгжүүлэх боломжтойгоор боловсруулагдсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлнэ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоов.

Хүснэгт 1. Хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг сонгон үнэлэх

Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд	Сонгосон зүйл заалт
19 дүгээр зүйл. Хариуцлага	19.1.Хэргийн оролцогч хэргийн талаарх үйл баримт, нэхэмжлэл болон хариу тайлбарын өөрчлөлт, нотолгооны хэрэгслийг хууль болон шүүхээс тогтоосон хугацаанаас хожимдуулан гаргасан тохиолдолд шүүх хүлээн авахгүй байж болно. 19.2.Хэргийн оролцогч хугацаа хожимдуулж буйгаа мэдээгүй эсвэл зориуд биш бөгөөд энэ талаар шүүхээс хэргийн оролцогчид мэдэгдэх боломжтой байсан тохиолдолд өмнөх заалт үйлчлэхгүй.
227-231 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцох	227 дугаар зүйл.Мэргэжилтэн оролцох 227.1.Шүүх нь маргаантай үйл баримт, эсхүл нотлох баримттай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай явуулахын тулд шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогчийн саналыг харгалзан мэргэжлийн тусгай мэдлэгт тулгуурласан тайлбарыг сонсохын тулд мэргэжилтнийг оролцуулж болно. 227.2.Мэргэжилтний тайлбарыг бичгээр, эсхүл шүүх хуралдаан болон шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд амаар тайлбарлуулна. 227.3.Шүүх нь нотлох баримтыг шинжлэн судлахдаа хэргийн оролцогчийн саналыг харгалзан мэргэжлийн мэдлэгт үндэслэсэн тайлбарыг сонсохын тулд мэргэжилтнийг ажиллагаанд оролцуулж болно. 227.4.Шүүх нь эвлэрэх санал гаргахдаа шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогчийн зөвшөөрлөөр тэдний аль аль нь хүрэлцэн ирэх боломжтой эвлэрэх санал гаргаж буй өдөр мэргэжлийн мэдлэгт үндэслэсэн тайлбарыг сонсохын тулд мэргэжилтэн этгээдийг ажиллагаанд оролцуулж болно. 228 дугаар зүйл. Зайнаас мэргэжилтэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох 228.1.Энэ хуулийн 227 дугаар зүйлд заасны дагуу шүүх мэргэжилтнийг ажиллагаанд оролцуулах тохиолдолд мэргэжилтэн нь хол зайтай газар амьдарч байгаа зэрэг бусад зохистой гэж үзэх тохиолдолд хэргийн оролцогчийн саналыг харгалзан тус зүйлийн заалтуудад заасны дагуу шүүх болон хэргийн оролцогчийн аль аль нь мэргэжилтэнтэй хоорондоо дуу

		хүлээн авагч, холбогч хэрэгслээр дамжуулан мэргэжилтнээр тус зүйлийн заалтуудад заасан тайлбар хийлгүүлж, асуулт асууж болно. 229 дүгээр зүйл. Мэргэжилтнийг оролцуулах тогтоолыг хүчингүй болгох 229.1.Шүүх нь зохистой гэж үзвэл хэргийн оролцогчийн хүсэлтээр болон өөрийн санаачилгаар мэргэжилтнийг ажиллагаанд оролцуулах шийдвэрээ хүчингүй болгож болно. Харин зохигч талууд аль аль нь хүсэлт гаргасан бол үүнийг хүчингүй болгох ёстой. 230 дугаар зүйл. Мэргэжилтнийг чөлөөлөх болон томилох тухай 230.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах мэргэжилтнийг хэргийн оролцогчийн саналыг харгалзан шүүх тухайн хэрэг бүрд нэр заан томилно. 230.2.Мэргэжилтэн нь байнгын бус байна. 230.3.Мэргэжилтэнд ажлын хөлс олгож, мөн тээвэр, орон байр, хоолны зардал олгоно. 231 дүгээр зүйл.Мэргэжилтнийг татгалзан гаргах 231.1.Мэргэжилтнийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргасан бол тухайн мэргэжилтнийг тухайн хүсэлтийн талаарх шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл хүсэлт гаргасан хэргийн ажиллагаанд оролцуулахгүй.
311-316	дугаар зүйл. Шүүхийн урьдчилсан хуралдаан	311 дүгээр зүйл.Урьдчилсан хуралдаан 311.1.Шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар хэргийн маргаатай үйл баримтыг тодорхойлох, нотлох баримт бүрдүүлэх ач холбогдлыг тодорхойлох, болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай бусад асуудлыг шийдвэрлэх зорилгоор шүүх урьдчилсан хуралдааныг явуулна. 311.2.Урьдчилсан хуралдааныг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулж буй шүүгч хийнэ. 312 дүгээр зүйл.Урьдчилсан хуралдаан хийх тоо, хугацаа 312.1.Урьдчилсан хуралдааныг хэд хэдэн удаа явуулж болно. 312.2.Урьдчилсан хуралдааныг шүүх хуралдаанаас өмнө, эсхүл шүүх хуралдаан хойшилсон тохиолдолд түүний дараа хийж болно. 313 дугаар зүйл.Урьдчилсан хуралдааныг товллох 313.1.Урьдчилсан хуралдааныг хэргийн оролцогч оролцох боломжтой өдөр товлно. 313.2.Урьдчилсан хуралдааны товыг гурваас доошгүй хоногийн өмнө хэргийн оролцогчид мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ. 314 дүгээр зүйл.Урьдчилсан хуралдаанд бэлтгэх 314.1.Шүүх хэргийн оролцогчоос урьдчилсан хуралдаанд хэлэх тайлбарыг бичгээр гаргуулна. 315 дугаар зүйл.Урьдчилсан хуралдаанаар хэлэлцэх асуудал 315.1.Шүүх урьдчилсан хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. 315.1.1.хэргийн маргаантай үйл баримтыг тодорхойлох; 315.1.2.хэрэгт цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэн судлах; 315.1.3.хэргийн оролцогчийн хүсэлтээр нотлох баримт бүрдүүлэх талаар шийдвэрлэх; 315.4.4.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай бусад

	асуудлыг шийдвэрлэх. 316 дугаар зүйл. Урьдчилсан хуралдааныг хаах 316.1.Урьдчилсан хуралдаан явагдаж дуусахад 316.2.Хэргийн оролцогч урьдчилсан хуралдаанд гаргасан хүсэлт, татгалзлын үндэслэлээ нотлох үүрэгтэй. 316.3.Урьдчилсан хуралдааныг шүүгч удирдан явуулж, хуралдааны тэмдэглэлтэй хэргийн оролцогч танилцах эрхтэй. 316.4.Урьдчилсан хуралдаанаар хэргийг агуулгаар нь хэлэлцэхгүй. 316.5.Талууд хүссэн, эсхүл шүүх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд урьдчилан хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд энэ талаар шүүгч захирамж гаргана.
337 дугаар зүйл. Хариуцагч хариу тайлбар ирүүлэлгүй шүүх хуралдаанд оролцох	337.1.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн ...-т заасан үүргээ биелүүлээгүй буюу хариу тайлбар ирүүлээгүй хэдий ч хэргийн бусад оролцогч шүүх хуралдаанд оролцож байгаа бол шүүх хуралдаан дээр тайлбар гаргаж болно. 337.2.Энэ хуулийн 337.1-т заасан тохиолдолд хэргийн бусад оролцогч шүүх хуралдаанд ирээгүй бол шүүх хуралдаан дээр тайлбар гаргах эрхгүй.

2.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хүснэгт 2. Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг сонгон үнэлэх

Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл заалт
13 дугаар зүйл. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах зарчим	13.1.Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй, үр нөлөөтэй байдлаар удирдан явуулна.
76-83 дугаар зүйл. Хамтран нэхэмжлэгч, хариуцагч	76 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох 76.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах тохиолдолд хэд хэдэн нэхэмжлэгч, эсхүл хэд хэдэн хариуцагч хамтран оролцож болно. 76.1.1.нэхэмжлэлийн зүйл болох эрх, үүрэг адил байх; 76.1.2.нэхэмжлэлийн зүйл болох эрх, үүрэг нь нэг ижил үйл баримт болон хууль зүйн үндэслэлтэй байх; 76.1.3.нэхэмжлэлийн зүйл болох эрх, үүрэг нь нэг төрлийн бөгөөд үйл баримт болон хууль зүйн нэг төрлийн үндэслэлтэй байх. 77 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцоход бие даасан байх зарчим 77.1.Хамтран оролцогчийн аль нэгэнд үүссэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөхцөл байдал нь бусад хамтран оролцогчдод нөлөөлөхгүй. 78 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй бүгд хамтран оролцох 78.1.Маргаантай эрх зүйн харилцаанд оролцогч бүх этгээд хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагчаар оролцох шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй бүгд хамтран оролцоно.

79 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй нэгдэж хамтран оролцох

79.1.Маргаантай эрх зүйн харилцааны оролцогч бүх этгээд хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагчаар оролцох шаардлагагүй ч, шүүхийн шийдвэр тухайн маргаантай эрх зүйн харилцаанд оролцогчдод бүгдэд нь нэгдмэл байдлаар үйлчилхээр бол зайлшгүй нэгдэж хамтран оролцоно.

79.2.Энэ хуулийн 79.1-д заасан тохиолдолд хамаарах этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамтран оролцогчоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

79.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамтран оролцогчоор оролцуулахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхтэй байна.

80 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй хамтран оролцох журам

80.1.Нэхэмжлэлийн зүйл хамтран оролцогчдын бүгдэд нь нэгдмэл байдлаар тогтоогдох шаардлагатай бол тэдгээрийн аль нэгний явуулсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүгдийнх нь ашиг сонирхолд нийцэж байх үед л хүчинтэй байна.

80.2.Өмнөх заалтад зохицуулсан тохиолдолд хамтран оролцогч аль нэг талын эсрэг нөгөө талын хийсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бүгдийнх нь эсрэг хүчинтэй байна.

80.3.Хамтран оролцогчийн аль нэгний хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл байгаа бол тухайн үндэслэл хамтран оролцогч бүгдэд нь үйлчилнэ.

81 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамтран оролцох

81.1.Шүүх шийдвэрээ гаргахаас өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх үед гуравдагч этгээдийг түүний хүсэлтээр болон хэргийн оролцогчийн хүсэлтээр энэ хуулийн 76.1-д заасан тохиолдолд хамаарах бол хамтран нэхэмжлэгч, эсхүл хамтран хариуцагчаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

81.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг оролцуулснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нөхцөл байдал үүснэ гэж шүүх үзвэл хамтран оролцогчоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаас татгалзаж болно.

81.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамтран оролцогчоор оролцуулахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй.

82 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох талаар мэдэгдэх

82.1.Хэргийн оролцогч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх явцад оролцох боломжтой гуравдагч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буйг мэдэгдэж болно.

83 дугаар зүйл.Хамтран оролцогч аль нэгийгээ төлөөлүүлэн оролцуулах

83.1.Хамтран нэхэмжлэгч буюу хамтран хариуцагч нь ашиг сонирхлын зөрчилгүй, уг хэргийг хянан шийдвэрлэхэд бүгд оролцох шаардлагагүй, түүнчлэн хэргийн шийдвэрт сөргөөр

	нөлөөлөхгүй гэж үзвэл аль нэгийгээ төлөөлүүлэн оролцуулж болно.
--	---

2.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хүснэгт 3. Хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг сонгон үнэлэх

Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
11 дүгээр зүйл. Үл маргах зарчим	11.1.Талууд гэрээндээ үүргээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн бол шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.
14 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч, шударгаар оролцох зарчим	14.1.Хэргийн оролцогч үнэнч, шударгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, эрхээ урвуулан ашиглахыг хориглоно.
15 дугаар зүйл. Тохирсон байх зарчим	15.1.Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон байх зарчим баримтална. 15.2.Шүүх хэргийн нарийн төвөгтэй байдал, ач холбогдол, шинж чанарыг харгалзан хянан шийдвэрлэх ажиллагааг харьцангуй байдлаар явуулна. 15.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн үйлдэлд хариуцлага оногдуулахдаа үйлдэлдээ санаатай, эсхүл болгоомжгүй хандсан эсэх, хор уршгийн хэмжээ, цар хүрээ, ач холбогдлыг харгалзан үзнэ. 15.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нарийн төвөгтэй байдал, шинж чанар, маргааны цар хүрээнд тохирсон, харьцангуй байна.
17 дугаар зүйл. Тайлбар гаргах үүрэг	17.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэслэл болж байгаа үйл баримтын талаар тайлбар гаргах үүрэгтэй. 17.2.Хэргийн оролцогчийн тайлбарт дурдаагүй үйл баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохыг хориглоно. 17.3.Хэргийн материал болон илэрхий дурдаагүй асуудал.
18 дугаар зүйл. Нотлох үүрэг	18.1.Хэргийн оролцогч өөрт ашигтай үйл баримтыг өөрөө нотлох үүрэг хүлээнэ. 18.2.Нотлох үүргийг материаллаг хуулийн дагуу хуваарилна. 18.3.Шүүхийн санаачилгаар нотлох баримт цуглуулахыг хориглоно.
19 дүгээр зүйл. Хариуцлага	19.1.Хэргийн оролцогч хэргийн талаарх үйл баримт, нэхэмжлэл болон хариу тайлбарын өөрчлөлт, нотолгооны хэрэгслийг хууль болон шүүхээс тогтоосон хугацаанаас хожимдуулан гаргасан тохиолдолд шүүх хүлээн авахгүй байж болно. 19.2.Хэргийн оролцогч хугацаа хожимдуулж буйгаа мэдээгүй эсвэл зориуд биш бөгөөд энэ талаар шүүхээс хэргийн оролцогчид мэдэгдэх боломжтой байсан тохиолдолд өмнөх заалт үйлчлэхгүй.

21 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр болон амаар явуулах	21.1.Хэргийн оролцогч нэхэмжлэл, хариу тайлбар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хүсэлт, гомдлоо бичгээр гаргана. 21.2.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдааны үед шүүгчийн зөвшөөрлөөр нэхэмжлэл, хариу тайлбарт оруулах өөрчлөлт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хүсэлт, гомдлоо амаар гаргаж болно.
251-264 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичиг хүргүүлэх	251 дүгээр зүйл.Шүүх өөрийн санаачилгаар баримт бичиг хүргүүлэх 251.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг шүүх өөрийн санаачилгаар хэргийн оролцогчид хүргүүлнэ. 252 дугаар зүйл.Баримт бичиг хүргэх этгээд 252.1.Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд баримт бичгийг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. 252.2.Хэргийн оролцогчийн мэдүүлсэн цахим шуудангаар баримт бичгийг хүргүүлж болно. 253 дугаар зүйл.Шүүгчийн туслах баримт бичиг хүргэх 253.1.Шүүгчийн туслах нь шүүхэд хүрэлцэн ирсэн этгээдэд өөрөө бичиг баримтыг гардуулж болно. 254 дүгээр зүйл.Баримт бичгийг гардуулах 254.1.Хуульд өөрөөр заагаагүй бол баримт бичгийг хүлээн авах ёстой этгээдэд нь гардуулан өгнө. 254.2.Энэ хуулийн 252.2-т зааснаар хэргийн оролцогч цахим шуудангийн хаягаа мэдүүлсэн бол цахим шуудангийн хаягаар баримт бичгийг илгээснээр гардуулсан тооцно. 255 дугаар зүйл.Баримт бичгийг гардуулахтай холбоотой онцгой тохиолдол 255.1.Энэ хуулийн-т заасан этгээдэд баримт бичиг хүргэх тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчид хүргүүлснээр гардуулсанд тооцно. 255.2.Хэд хэдэн этгээд хамтран төлөөлж байгаа тохиолдолд баримт бичгийг тэдний аль нэгэнд нь хүргүүлснээр гардуулсанд тооцно. 255.3.Хорих газарт хоригдож байгаа этгээдэд баримт бичиг хүргэх тохиолдолд хорих газрын даргад хүргүүлснээр гардуулсанд тооцно. 256 дугаар зүйл.Баримт бичиг хүргэх газар 256.1.Баримт бичгийг хүлээн авах ёстой этгээд нь хүн бол баримт бичгийг түүний оршин суугаа/оршин байгаа/ газар, эсхүл аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг, эсхүл албан газрын хаягаар хүргүүлнэ. 256.2.Энэ хуулийн 256.1-д заасан газар мэдэгдэхгүй байгаа, эсхүл тухайн газарт баримт бичиг хүргүүлэхэд бэрхшээлтэй байгаа бол түүний хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ зэрэг хэлцлийн үндсэн дээр ажиллаж байгаа этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг, эсхүл албан газрын хаягаар хүргүүлж болно. 256.3.Баримт бичгийг хүлээн авах ёстой этгээд нь хуулийн этгээд бол баримт бичгийг түүний ажил хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага нь байгаа газрын хаягаар хүргүүлнэ.

256.4.Хэргийн оролцогчийн оршин суугаа/оршин байгаа/ болон бусад хүргэх ёстой хаяг мэдэгдэхгүй байгаа тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагаас оршин суух хаягийг тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

257 дугаар зүйл.Баримт бичиг хүргүүлэх газраа мэдэгдэх үүрэг

257.1.Хэргийн оролцогч, түүний төлөөлөгч нь баримт бичиг хүлээн авах газрын, эсхүл цахим шуудангийн хаягаа хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.

257.2.Хэргийн оролцогч, түүний төлөөлөгч нь баримт бичиг хүлээн авах газрын, эсхүл цахим шуудангийн хаягаа мэдэгдсэн бол түүний мэдэгдсэн хаягаар баримт бичгийг хүргүүлнэ.

257.3.Энэ хуулийн 257.2-т заасан цахим шуудангийн хаягаа мэдүүлэх баримт загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

258 дугаар зүйл.Баримт бичгийг уулзсан газарт гардуулах

258.1.Баримт бичгийг хүргэхдээ тухайн этгээдтэй уулзсан газарт гардуулж болно.

259 дүгээр зүйл.Баримт бичгийг хамааралтай этгээдэд хүргэх болон үлдээгээд явах

259.1.Баримт бичиг хүргэх ёстой газарт баримт бичиг хүлээн авах ёстой этгээдтэй таарахгүй бол түүний ажилтан, эсхүл насанд хүрсэн хамт амьдарч байгаа этгээдэд баримт бичгийг гардуулж болно.

259.2.Энэ хуулийн 256.1-д заасан газар мэдэгдэхгүй байгаа, эсхүл тухайн газарт баримт бичиг хүргүүлэхэд бэрхшээлтэй байгаа бол түүний хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ зэрэг хэлцлийн үндсэн дээр ажиллаж байгаа этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг, эсхүл албан газрын хаягаар хүргүүлж болно.

259.3.Баримт бичиг хүлээн авах ёстой этгээд, эсхүл энэ хуулийн 259.1-д заасны дагуу баримт бичиг хүлээн авах ёстой этгээд нь зохих шалтгаангүйгээр хүлээн авахаас татгалзсан бол тухай хаягт үлдээнэ.

260 дугаар зүйл.Хилийн чандад баримт бичиг хүргэх

260.1.Хилийн чанадад баримт бичиг хүргүүлэх шаардлагатай бол шүүх өөрөө, эсхүл эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж хүргүүлж болно.

260.2.Хилийн чандад баримт бичгийн тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр, ийм гэрээ байхгүй тохиолдолд дипломат шугамаар хүргүүлэх журмыг баримтална.

260.3.Энэ хуулийн 260.1-д заасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

261 дүгээр зүйл.Баримт бичиг хүргэснийг баталгаажуулах

261.1.Баримт бичиг хүргэсэн этгээд нь баримт бичиг хүргэсэн тухай агуулгыг бичгээр тэмдэглэн, шүүхэд гаргаж өгнө.

262 дугаар зүйл.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэх

262.1.Шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр нийтэд мэдээлэх замаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд араах тохиолдолд мэдэгдэж болно:

262.1.1.хэргийн оролцогчийн оршин суугаа, оршин байгаа болон бусад хүргэх ёстой хаяг мэдэгдэхгүй байгаа тохиолдолд;

	262.1.2.энэ хуулийн 259.1-д заасан арга хэмжээ авсан боловч хүргүүлж чадаагүй тохиолдолд; 262.1.3.Хилийн чандад баримт бичиг хүргэхэд 260 дугаар зүйлд заасны дагуу хүргэх боломжгүй, эсхүл 260 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн боловч хүргэгдээгүй тохиолдолд; 251.1.4.энэ хуулийн 260 дугаар зүйлд заасны дагуу гадаад улсын хариуцсан байгууллагад даалгавар илгээснээс 6 сар өнгөрсөн боловч баримт бичиг хүргэгдсэн талаар баталсан баримт ирээгүй тохиолдолд. 262.2.Энэ хуулийн 262.1-д зааснаас гадна шүүх шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг нийтэд мэдэгдэх захирамж гаргаж болно. 262.3.Шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд хоёр удаа нийтэд мэдээлэх замаар мэдэгдэнэ. 263 дугаар зүйл.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэх арга 263.1.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхдээ шүүх нь бичиг баримтыг хадгалж ямар ч үед баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд гардуулах боломжтой тухай шүүхийн нийтэд мэдээлэх хэрэгслээр мэдээлнэ. 264 дүгээр зүйл.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэснээр үүсэх үр дагавар 264.1.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхэд энэ хуулийн 263.1-д заасны дагуу мэдээлсэн өдрөөс 2 долоо хоног өнгөрснөөр хүргүүлсэнд тооцно. 264.2.Гадаад улсад хүргүүлэх баримт бичиг бол энэ хуулийн 263.1-д заасны дагуу нийтэд зарлах хугацаа нь 6 долоо хоног байна.
327 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль нэг нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар	327.1.Хэргийн оролцогч шүүх хуралдаанд ирээгүй, эсхүл хүрэлцэн ирсэн хэдий ч хэргийн талаар мэтгэлцээгүй бол шүүх тухайн этгээдийн гаргасан нэхэмжлэл, хариу тайлбар, нэмэлт тайлбартаа дурдсан тайлбарыг шүүх хуралдаанд гаргасан гэж үзэж, шүүх хуралдаанд ирсэн хэргийн бусад оролцогчийг мэтгэлцүүлнэ. 327.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардан авсан боловч хариу тайлбар ирүүлээгүй бөгөөд шүүх хуралдаан ирээгүй тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож, энэ хуульд заасан хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэж шүүгчийн захирамж гаргана. 327.3.Хариуцагчид нэхэмжлэлийг нийтэд мэдээлэх замаар гардуулсанд тооцсон бөгөөд шүүх хуралдаан ирээгүй тохиолдолд шүүх нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон бусад баримт нотолгоог үндэслэн хэргийг хянан шийдвэрлэнэ.
328 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль аль нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар	328.1.Хэргийн оролцогчийн аль аль нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэдгээрийн эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл шүүх хуралдааныг хойшлуулна.
329 дүгээр зүйл. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд ирээгүйн үр	329.1. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд хүрэлцэн ирж чадаагүй бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан хугацааны дотор шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, эсхүл

дагавар	хойшлуулах боломжгүй бол хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн хэргийг хянан хэлэлцэнэ. 329.2.Хариуцагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд хүрэлцэн ирж чадаагүй тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан хугацааны дотор шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, эсхүл хойшлуулах боломжгүй бол хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн хэргийг хянан хэлэлцэнэ. 329.3.Хэргийн оролцогчийн эзгүйд хэргийг хянан шийдвэрлэх тохиолдолд түүний өмнө нь бичгээр гаргасан тайлбарыг шүүх хуралдаан дээр гаргасантай адилтгаж үзнэ. 329.4.Хэргийг оролцогчийн эзгүйд хянан хэлэлцсэн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй.
338 дугаар зүйл. Хэргийн оролцогч бичгээр гаргасан тайлбартаа дурдаагүй үйл баримтын талаар шүүх хуралдаанд тайлбар гаргах	338.1.Хэргийн бусад оролцогч шүүх хуралдаанд ирээгүй бол хэргийн оролцогч шүүх хуралдаанаас өмнө нь гаргасан нэхэмжлэл, хариу тайлбар, нэмэлт тайлбартаа дурдаагүй үйл баримтын талаар шүүх хуралдаан дээр тайлбар гаргах эрхгүй.

2.4.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд практик хэрэглээний явцад үр нөлөө нь тодорхой болохуйц зохицуулалтыг сонгон авсан болно. Сонгосон зүйл заалтуудыг дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4. Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг сонгон үнэлэх

Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
148-155 дугаар зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг бүрдүүлэх	148 дугаар зүйл.Эсрэг талаас бичмэл нотлох баримт, эд мөрийн баримт гаргуулах 148.1.Шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр хэргийн үйл баримтыг тогтооход шаардлагатай бичмэл нотлох баримт болон эд мөрийн баримтыг бусад хэргийн оролцогчоос гаргуулж болно. 149 дүгээр зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гаргах үүрэг 149.1.Хэргийн үйл баримтыг тогтооход зайлшгүй шаардлагатай бичмэл нотлох баримт болон эд мөрийн баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр эзэмшилдээ байлгаж байгаа хэргийн оролцогч бус этгээд тухайн нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. 150 дугаар зүйл.Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөх 150.1.Иргэн, хуулийн этгээд шүүхээс шаардсан бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг шүүхээс заасан хугацаанд гаргаж өгнө. Хэрэв иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гаргаж өгөх боломжгүй бол шүүхэд мэдэгдэнэ. 151 дүгээр зүйл.Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг албадан гаргуулах

151.1.Энэ хуулийн 149.1-д заасан нотлох баримтыг гаргаж өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзвал түүнийг албадан гаргуулна.

152 дугаар зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөхөөс татгалзах эрх

152.1.Ажил үүргээ гүйцэтгэх явцад хэргийн үйл баримтын талаар үйлдсэн сэтгэл зүйч, эвлэрүүлэн зуучлагч, хэргийн оролцогчийн төлөөлөгч, өмгөөлөгчийн бичмэл нотлох баримт болон бусад баримтыг гарган өгөхөөс татгалзах эрхтэй.

152.2.Хуульд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой бичмэл нотлох баримт болон бусад баримт баримтыг шаардахыг хориглоно.

153 дугаар зүйл.Татгалзах эрхтэй эсэхийг шийдвэрлэх

153.1.Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөхөөс татгалзах эрхтэй эсэхийг шийдвэрлэхийн тулд тухайн нотлох баримтыг мэдэлдээ байлгаж байгаа этгээдээс нотлох баримтыг гаргуулж болно. Энэ тохиолдолд шүүхээс бусад этгээд гаргасан нотлох баримттай танилцахыг хориглоно.

154 дүгээр зүйл.Хэргийн оролцогч бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөөгүй тохиолдол үүсэх үр дагавар

154.1.Хэргийн оролцогч нотлох баримт гаргуулах шийдвэрийг биелүүлээгүй бол шүүх тухайн тухайн нотлох баримттай холбоотой эсрэг талын тайлбарыг үнэн гэж үзэж болно.

154.2.Хэргийн оролцогч эсрэг тал ашиглахаас саад хийх зорилгоор гаргаж өгөх үүрэг бүхий баримт бичгийг устгах болон бусад байдлаар ашиглах боломжгүй болгосон бол энэ хуулийн 154.1-т мөн адил байна.

154.3.Энэ хуулийн 154.1, 154.2-т заасан тохиолдолд эсрэг тал нь тухайн нотлох баримтын агуулгатай холбогдуулж тодорхой тайлбар гаргах болон тухайн нотлох баримтаар тогтоох ёстой үйл баримтыг бусад нотлох баримтаар нотлох нь илэрхий төвөгтэй байгаа бол шүүх тухайн үйл баримтын талаарх эсрэг талын тайлбарыг үнэн гэж үзэж болно.

155 дугаар зүйл.Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөөгүй тохиолдол хүлээх хариуцлага

155.1.Энэ хуулийн 150.1-д заасан шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй гэм буруутай албан тушаалтан, иргэнд зохих хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төсөл нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар тогтоох юм. Уг шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэхдээ тодорхой стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй тул хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхээр сонгосон болно.

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлт ба шалгах хэрэгсэл

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод хүрэх байдлын дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл нь ойлгомжтой байдлаар бичигдсэн эсэхийг шалгана.
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийг хэрэгжүүлэх шүүгч нарын хуулийн төслийг хүлээн зөвшөөрч буй эсэх талаар судалгаа хийнэ.
4	Практикт хэрэгжих боломж	Практикт хэрэгжих боломжийг шалгах: Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг аргачлалын 4.6-т заасан асуултад хариулах замаар шалгана.
5	Харилцан уялдаа	Харилцан уялдааг шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгах ба хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

1. Хуулийн төслийн 19 дүгээр зүйл. Хариуцлага

19.1.Хэргийн оролцогч хэргийн талаарх үйл баримт, нэхэмжлэл болон хариу тайлбарын өөрчлөлт, нотолгооны хэрэгслийг хууль болон шүүхээс тогтоосон хугацаанаас хожимдуулан гаргасан тохиолдолд шүүх хүлээн авахгүй байж болно.

19.2.Хэргийн оролцогч хугацаа хожимдуулж буйгаа мэдээгүй эсвэл зориуд биш бөгөөд энэ талаар шүүхээс хэргийн оролцогчид мэдэгдэх боломжтой байсан тохиолдолд өмнөх заалт үйлчлэхгүй.

Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч, тэр хэрээр хэргийн оролцогчийн эрх зөрчигдөн шүүхэд хандах замаар

эрхээ сэргээлгэх нь цаг хугацаа, эдийн засгийн хувьд бодит байдал дээр хохиролтой байдаг талаар дурджээ. Улмаар одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хийсэн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаагаар Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд хэргийг хэлэлцэх нийт 36,691 шүүх хуралдаан зарлагдсанаас 21,619 хурал буюу 54.4 хувь нь хойшлогдсон байна. Хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацааг тооцоолж гаргахад анхан шатны шүүх дунджаар нэг хэргийг 30-120 хоног, зарим төрлийн хэргүүд түүнээс дээш 1-3 жилийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж байгаа талаар дурдсан байна.³

Түүнчлэн, Улсын Дээд Шүүхээс хийсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа хугацаа хэтэрсэн болон түдгэлзүүлсэн хэргийн судалгааны тоймоос үзэхэд, 2019 оны 5 сарын 1-ний байдлаар нийт ажиллагаанд байгаа хэргийн 47 хувь нь 1-60 хоног, 20 хувь нь 61-120 хоног, 6 хувь нь 121-150 хоног, 27 хувь нь 151-ээс дээш хоногоор буюу иргэний хэрэг үүсгэснээс хойш 240 хоногийн хугацаа хэтрэлттэй байх бөгөөд үүнд хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан 90 хоногийн хугацаа ороогүй⁴ талаар дурджээ.

Дээрхээс дүгнэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан хугацаанд хэрэг маргаан шийдвэрлэгдэхгүй байгаа нь тодорхой харагдах бөгөөд шүүх хуралдаан ихээр хойшлогддог байна. Шүүх хурал хойшлогдож буй шалтгаан нөхцөлийг судалж үзвэл хэргийн оролцогчоос шалтгаалсан үндэслэл болон шүүхээс шалтгаалсан үндэслэл гэж дараах байдлаар хоёр ангилж болохоор байна. Үүнд:

Нэгд, Хэргийн оролцогчоос шалтгаалан шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлд шинээр нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримт гаргуулах, бүрдүүлэх хүсэлт гаргах, гэрч асуулгах, шинжээч томилуулах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, өөрчлөх, тодруулах, өмгөөлөгч авах, хэргийн материалтай танилцах, сөрөг нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаан давхардах, өвчтэй чөлөөтэй байх, хэргийн оролцогч шүүх бүрэлдэхүүнээс татгалзах, бие даасан шаардлага гаргасан, гаргаагүй гуравдагч этгээдээр оролцох зэрэг үндэслэлүүд хамаарч байна. Хоёрт, шүүхээс шалтгаалсан үндэслэлээр шүүх хуралдаан хойшлогдох үндэслэлд хэргийн оролцогчдод хуралдааны тов мэдэгдээгүй, хэргийн материалтай танилцах боломж олгоогүй, өмнө гаргасан шүүчгийн захирамжийн биелэлт хангагдаагүй, гэрч, хариуцагчийг албадан ирүүлэх, шүүх хуралдаанд биечлэн оролцуулах зэрэг үндэслэлүүд хамаарч байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунжирч буй шалтгааныг судалж үзэхэд хэргийн оролцогч нотлох баримт гаргаж өгөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлтийг хэдэн ч удаа шүүх хуралдааны явцад гаргаж өгөх боломжтой байдагтай холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх 60 хоногийн хугацаанд хэргийн оролцогч хуульд заасан эрхээ хэрэгжүүлж, нэхэмжлэл болон татгалзлаа нотлох баримтаа гаргаж өгөх, хуульд заасан нотолгооны хэрэгслээр нотлох баримт бүрдүүлэх эрхтэйгээс гадна үүрэгтэй. Гэтэл хуульд заасан хугацаанд хэргийн оролцогч хэрэгт ач холбогдол бүхий өөрт байгаа баримтаа шүүхэд гаргаж өгөхгүй байх, нотлох баримтаа бүрдүүлүүлэхээр хүсэлт гаргаагүй байж, хэргийг шийдвэрлэх шүүх хуралдаан дээр нэмэлт ажиллагаа хийлгэх, нотлох баримт гаргаж өгөх, гаргуулах зэрэг хүсэлтүүдийг цувруулан гаргах боломжтой байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нөхцөлийг бүрдүүлж байна.

³ Хуулийн төслийн үзэл баримтлалаас

⁴ http://www.supremecourt.mn/files/20220/0_1642583446.pdf 2023.12.08-ны өдөр үзсэн.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2-т “Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцтоой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай бол шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулж болно” гэж заасан байх бөгөөд энэ заалтыг хэрэглэх урьдчилсан нөхцөл нь урьдчилан хэрэгжүүлэх боломжтой байсан боловч шүүх хуралдааны үед нотлох баримт гаргаж өгсөн нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол шинжлэн судалж, нэг удаа шүүх хуралдааныг хойшлуулж болохоор тусгаж өгсөн. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй бол нэмэлт тайлбар, нотлох баримтыг хүлээн авахгүй байж болохоор байна.

Мөн хуулийн 105.2-т нэмж тодруулан тусгаж өгөх шаардлагатай зүйл бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлтийг гэж нэмж оруулж өгөх шаардлагатай байна. Тухайлбал, УДШ-ээс хийсэн судалгаагаар “нотлох баримт гаргах, бүрдүүлэх үндэслэлээр шүүх хуралдаан хамгийн олон удаа хойшилсон нь судалгаагаар тогтоогдсон байна” гэжээ.⁵

Хуулийн төслийн 19.1 болон 19.2-ийн талаар Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчдээс санал авахад хуулийн төслийн 19.1-ийг зорилгодоо хүрэх боломжтой, хүлээн зөвшөөрөхүйц, хэрэгжих боломжтой зохицуулалт гэж үзэж байв. Учир нь одоо хэрэгжиж буй ИХШХШТХ-ийн 105.2-г амь оруулсан, хэргийн оролцогчдыг хариуцлагажуулсан, нэмэлт тайлбар, нотлох баримт гаргах, нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлтийг цувуулж нэг нэгээр нь гаргах замаар хэргийн оролцогч эрхээ урвуулан ашиглах боломжийг нь хаасан зохицуулалт гэж дүгнэсэн.

Хуулийн төслийн 19.1 дүгээр зүйлд *авахгүй байж болно* биш *авахаас татгалзана* гэж өөрчлөх шаардлагатай. Хугацаа тогтоож л байгаа учраас авахаас татгалзана гэсэн нь зүйтэй. Хэрэв авахгүй байж болно гэж зохицуулбал шүүх тухайн хүсэлтийг авж ч болно, авахгүй байсан ч болно гэх нөхцөл байдалд хүргэнэ. Ингэснээр хугацаа тогтоосны ач холбогдол байхгүй болно.

Хуулийн төслийн 19.2 дугаар зүйлд хугацаа хожимдуулсан хүндэтгэн үзэх шалтгаанаа *нотолбол* гэдэг санааг зайлшгүй оруулах шаардлагатай. Энэ заалт нь хэргийн оролцогчийг хариуцлагажуулж байгаа заалт учраас шүүхээс хэргийн оролцогчид мэдэгдэх боломжтой байсан тохиолдолд гэх шаардлагагүй. Хэргийн оролцогч өөрөө л мэдээд хариуцлагатай байх үүрэгтэй учраас шүүх нэмэлт ажил хийж заавал сануулаад байх шаардлагагүй. Тиймээс шүүхээс мэдэгдэх гэдгийг хаах нь зүйтэй.

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас...

Иймд хуулийн төслийн 19 дүгээр зүйл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрэх, сунжрах нөхцөл байдлыг хаасан, хэрэг маргааныг түргэн шуурхай явуулж шийдвэрлэх зорилгод хүрэх зохицуулалт байна.

⁵ http://www.supremecourt.mn/files/20220/0_1642583446.pdf 2023.12.08-ны өдөр үзсэн.

Тус судалгаагаар “судалгаанд хамрагдсан хугацаа хэтэрсэн нийт 504 хэрэгт шүүх хуралдааныг 2222 удаа хойшилсон байгаагаас нотлох баримт гаргах үндэслэлээр 603 удаа шүүх хуралдаан хойшилсон нь нийт хойшлогдсон үндэслэлийн 27.1 хувийг эзэлж байна” гэжээ.

2. Хуулийн төслийн 227-231 дүгээр зүйл. Мэргэжилтэн оролцох

227 дугаар зүйл.Мэргэжилтэн оролцох

227.1.Шүүх нь маргаантай үйл баримт, эсхүл нотлох баримттай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай явуулахын тулд шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогчийн саналыг харгалзан мэргэжлийн мэдлэгт тусгай мэдлэгт тулгуурласан тайлбарыг сонсохын тулд мэргэжилтнийг оролцуулж болно.

227.2.Мэргэжилтний тайлбарыг бичгээр, эсхүл шүүх хуралдаан болон шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд амаар тайлбарлуулна.

227.3.Шүүх нь нотлох баримтыг шинжлэн судлахдаа хэргийн оролцогчийн саналыг харгалзан мэргэжлийн мэдлэгт үндэслэсэн тайлбарыг сонсохын тулд мэргэжилтнийг ажиллагаанд оролцуулж болно.

227.4.Шүүх нь эвлэрэх санал гаргахдаа шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогчийн зөвшөөрлөөр тэдний аль аль нь хүрэлцэн ирэх боломжтой эвлэрэх санал гаргаж буй өдөр мэргэжлийн мэдлэгт үндэслэсэн тайлбарыг сонсохын тулд мэргэжилтэн этгээдийг ажиллагаанд оролцуулж болно.

Хуулийн төслийн 227 дугаар зүйлээс 231 дүгээр зүйлд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “Мэргэжилтэн оролцох” тухай ойлголт цоо шинээр тусгагдсан. Манай улсын одоогийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг шаардагдах аливаа асуудлыг тодруулахын тулд ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйлд заасны дагуу хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүгчийн санаачилаар шинжээч томилдог. Тэгвэл заавал шинжээч оролцуулах шаардлагагүйгээр шүүгчид тусгай мэдлэг шаардлагатай тохиолдолд мэргэжилтэн оролцуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай явагдахад ихээхэн түлхэц үзүүлдэг байна.

Мэргэжилтэн оролцуулах нь шинжээч томилохоос ялгаатай нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй мэргэжилтнээс шүүгч, хэргийн оролцогчид зөвхөн тусгай мэдлэг шаардагдах зүйлсийг тодруулах, тухайн салбарын мэргэжлийн ойлголтуудыг үнэн зөвөөр авах зорилготой ажиллагаа бөгөөд мэргэжилтний тайлбар нь хэрэгт нотлох баримтаар үнэлэгдэхгүй буюу шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

Хуулийн төслийн дээрх заалтуудтай холбоотойгоор шүүгчид зарчмын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг түргэсгэх зорилготой ажиллагаа хуулийн төсөлд тусгагдсан нь өнөөгийн манай улсын хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа учраас энэ ажиллагааг хүлээн зөвшөөрөх боломжтой гэж үзсэн. Гэвч хуулийн төслийн 229 дүгээр зүйлд мэргэжилтэн оролцуулах тогтоолыг хүчингүй болгох тухай зохицуулалт оруулах нь зохимжгүй гэж байна. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцуулахаар нэгэнт тогтсон л бол түүнээс мэргэжлийн тайлбар авч процессыг үргэлжлүүлэх нь зүйтэй. Учир нь мэргэжилтэн оролцох тухай асуудал нь шүүхийн зардалтай шууд хамааралтай юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцуулахаар шийдвэрлэсэн боловч хэргийн оролцогч аль аль нь хүсэлт гаргасан тохиолдолд тус хүчингүй болгох тухай төсөлд тусгагдсан байдлыг анхаарах шаардлагатай юм.

Тусгай мэргэжилтэн оролцуулах талаар шүүх шийдвэрлэсэн атлаа хэргийн оролцогчид хүсэлт гаргах замаар мэргэжилтэн оролцуулах явдлыг зогсоох зохицуулалтын ач холбогдол бүрхэг байна. Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогчид хүсэлтээсээ татгалзсан нь тусгай мэдлэг шаардлаггүй гэж шууд дүгнэх үндэслэл болохгүй юм. Иймд энэ шийдвэрийг шүүх шийдвэрлэх нь зохимжтой юм. Мөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд

оролцох мэргэжилтнийг сонгох шалгуурыг тодорхой болгох шаардлагатай талаар судалгаанд оролцсон шүүгч нарын зүгээс онцолж байв.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцохтой холбоотой ажиллагааг дэлхийн олон улс орнууд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашигладаг. Тухайлбал, Азийн орнуудаас Япон, Солонгос, Хятад, Сингапур, мөн Европын холбооны 28 улсын 20 улс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцуулах тогтолцоотой байна.

Тухайлбал, Япон Улсын хувьд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 92.2 дугаар зүйлд заасны дагуу шүүхээс шаардлагатай тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдааны шатанд шүүгч тухайн хэргийн маргааны зүйл, нотлох баримттай холбоотой тусгай мэдлэг шаардагдах асуудлыг мэргэжилтэн оролцуулах замаар тодруулж болох бөгөөд мэргэжилтэнийг шүүх өөрөө сонгож оролцуулдаг байна.⁶ Түүнчлэн мэргэжилтэнийг томилох тухай тусгайлсан журам мөрдөгддөг бөгөөд тус журмын 1 дүгээр зүйлд заасны дагуу Улсын дээд шүүхээс шалгуур хангасан этгээдүүдийг 2 жилийн хугацаатай шат шатны шүүхүүдэд харьяалуулан шүүхийн орон тооны бус ажилтны статустайгаар томилдог байна.

Үүнтэй адилаар манай улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцуулах тогтолцоо бодитоор биелэлээ олохын тулд чухам хэнийг мэргэжилтэн гэж үзэх, тэдгээрт ямар шалгуур тавигдах, мөн ямар байгууллагаас мэргэжилтэн гэж томилох зэрэг тусгайлсан журмыг боловсруулах, эсхүл хууль тогтоомжид тусгах замаар дээрх хуулийн заалтын хэрэгжилтийг амь оруулах нь зүйтэй. Европын улс орнуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох мэргэжилтэн мэргэжлийн зэрэгтэй, ажилласан жилийн туршлагатай байхыг шаарддаг бөгөөд тухайн улсаасаа шалтгаалан шүүх эсвэл тусдаа чиг үүрэг бүхий байгууллага шаардлага хангасан мэргэжилтнийг бүртгэдэг байна.⁷ Мөн мэргэжилтэнээс асуумж авч шалгуурт нийцэж буй эсэхийг нягталдаг байна. Бусад улс орны дээрх туршлагаас үзэхэд мэргэжилтэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход тухайн мэргэжлийн салбарын талаарх асуудлыг өөрийн мэдлэг чадварт үндэслэн тайлбарлаж чадахуйц мэргэжилтнийг сонгож бүртгэлжүүлэх зэрэг бүхий процедурыг нарийвчилсан журмаар зохицуулснаараа энэхүү ажиллагаа практикт бодитоор хэрэгжих суурь болжээ.

3. Хуулийн төслийн 311-316 дугаар зүйл. Шүүхийн урьдчилсан хуралдаан

311 дүгээр зүйл. Урьдчилсан хуралдаан
312 дүгээр зүйл. Урьдчилсан хуралдаан хийх тоо, хугацаа
313 дугаар зүйл. Урьдчилсан хуралдааныг товлох
314 дүгээр зүйл. Урьдчилсан хуралдаанд бэлтгэх
315 дугаар зүйл. Урьдчилсан хуралдаанаар хэлэлцэх асуудал
316 дугаар зүйл. Урьдчилсан хуралдааныг хаах

Монгол Улсын Шүүх эрх мэдлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ зорилготой Шүүхийн индекс 2021 судалгаагаар 6 үндсэн, 42 дэд хэмжигдэхүүнийг ашиглаж дүгнэсэн байна. Үүний нэг хэмжэгдэхүүн нь “Шүүх хэрэг, маргааныг боломжийн хугацаанд

⁶松本博之、上野泰雄「民事訴訟法（8版）」、弘文堂（2015）、94頁

⁷ Alain Nuée (2015) “Civil-law expert reports in the EU: national rules and practices”, p.17 <https://shorturl.at/jDKV9>

шийдвэрлэдэг эсэх” хэмжиж, үнэлгээ хийсэн байх бөгөөд олон нийт 24.27 хувь нь боломжийн хугацаанд хэрэг маргааныг шийдвэрлэдэг гэж хариулсан нь нийт хэмжигдэхүүнүүдээс хамгийн бага оноо авсан үзүүлэлт болжээ. Үүнээс дүгнэж үзвэл шүүхийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх хугацаа урт, удаашралтай, шүүх хурал олон удаа хойшлогддог болох нь харагдана.

Хуулийн төсөлд тусгагдсан Урьдчилсан хуралдааны зохицуулалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай, үр нөлөөтэй явуулахад чиглэсэн гол зохицуулалт байна. Урьдчилсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хуулийн төслийн 315 дугаар зүйлийн 315.1-т “хэргийн маргаантай үйл баримтыг тодорхойлох, хэрэгт цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэн судлах, хэргийн оролцогчийн хүсэлтээр нотлох баримт бүрдүүлэх талаар шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх”-ээр тусгаж өгчээ. Эдгээр нь дараах байдлаар чухал ач холбогдолтой байна. Үүнд:

1. Урьдчилсан хуралдаанаар талуудын маргаж байгаа үйл баримтыг тодорхой болгох боломжтой болно. Ингэснээр талуудын маргаж байгаа асуудлыг тодорхой болгосноор нэхэмжлэлийн шаардлага тодорхойгүй, нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлоогүй зэрэг шалтгаанаар шийдвэр хүчингүй болох тохиолдлыг үгүй болгох юм. Түүнчлэн, нэхэмжлэлийн шаардлагаа тодруулах, тодорхой болгох нэмэлт ажиллагаа хийх, үүнээс улбаалан мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх үүднээс шүүх хуралдааныг хойшлуулах нөхцөл байдлыг хумих боломжтой.
2. Хэргийн маргаантай үйл баримтыг тодорхой болгосноор талуудад нэхэмжлэлийн шаардлага болон татгалзлын үндэслэл, нотлох баримтаа бүрдүүлэхэд тодорхой хэмжээнд дөхөмтэй болж, ямар нотлох баримт бүрдүүлэх талаарх хүрээ хязгаар нь тодорхой болох давуу талтай.
3. Хэргийн маргаантай үйл баримтыг тодорхойлсноор хэргийн оролцогчийн хүсэлтээр ямар нотлох баримт бүрдүүлэх хүрээ нь хумигдсанаар шүүхийн хийх ажиллагаа тодорхой болж, зөвхөн маргаантай үйл баримттай холбоотой нотлох баримтыг бүрдүүлэх боломж бүрдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү түргэн шуурхай явагдах боломжтой болно.
4. Урьдчилсан хуралдаанаар нотлох баримт гаргуулах, бүрдүүлэхтэй холбоотой талуудын хүсэлтүүдийг нэг мөр шийдвэрлэж дууссанаар шүүх хуралдаан болгон дээр нотлох баримт гаргуулах, бүрдүүлүүлэх хүсэлт гаргах боломжийг хязгаарлах юм. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг санаатайгаар удаашруулахын тулд хүсэлтийг нэг нэгээр нь гаргах байдал үгүй болох ба хэргийн оролцогч эрхээ урвуулан ашиглах нөхцөл байдлыг хязгаарлах ач холбогдолтой.
5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх боломжтой болсноор дараа нь ямар нэгэн байдлаар шүүх хуралдаан хойшлогдох, хойшлуулах хүсэлт гаргах зэрэг нөхцөл байдлыг хумих зорилготой. Тухайлбал, өмгөөлөгч авах, өмгөөлөгч нь хэргийн материалтай танилцах зэргээр шүүх хуралдаан удаа дараа хойшлогдох нөхцөлийг хязгаарлах боломжтой болно.

6. Одоогийн ИХШХШТХ-аар шүүх хуралдаан зарлагдаж хэргийн оролцогчийн ирцийг тодруулах, эсхүл шүүх хуралдаанд гаргаж өгөх нотлох баримт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлтийг шийдвэрлэхээр хэд хэдэн удаа хойшилдог. Тодруулбал, талуудын маргаж байгаа үйл баримтруу оролгүйгээр шүүх хуралдаан хойшилдог ба талуудын маргаж байгаа үйл баримтын талаар хэргийг шийдвэрлэх эцсийн шүүх хуралдаан дээр хэлэлцдэг нь тус шүүх хуралдааны явцад ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.9-т заасны дагуу шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах эрхийг шүүгчид хуулиар олгосон байдаг тул шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах тохиолдол гардаг. Үүний улмаас нэг талд ашигтай нотлох баримт бүрдүүлсэн, хөндлөнгийн байж чадаагүй гэх үндэслэлээр шүүгчийг хардах, улмаар Шүүхийн сахилгын хороонд гомдол гаргах нөхцөл байдлыг бүрдүүлдэг. Гэвч нөгөө талаар шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагатай бөгөөд бодит үнэнд нийцсэн шийдвэр байх шаардлагатай байдаг. Энэ үүднээс үзвэл шүүгч хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргахын тулд залшгүй шаардлагатай нотлох баримтыг өөрийн санаачилгаар бүрдүүлэх эрх хэмжээг зөвтгөх боломжтой байдаг. Урьдчилсан хуралдаантай болсноор 38.9-д зааснаар шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй болох боломжтой.

Хуулийн төслөөр урьдчилсан хуралдаанаар хэргийг агуулгаар нь хэлэлцэхгүй талаар тусгаж өгсөн байх бөгөөд урьдчилсан хуралдаанд гаргах тайлбарыг бичгээр гаргах, урьдчилсан хуралдаанд гаргах хүсэлт болон татгалзлын үндэслэлээ нотлох үүрэгтэй талаар тусгаж өгсөн нь урьдчилсан хуралдааныг илүү үр дүнтэй болгож, талуудыг хариуцлагажуулж өгсөн байна.

Хуулийн төслийн 311 дүгээр зүйлийн 311.1-т “Шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар ...” урьдчилсан хуралдааныг явуулж болохоор тусгажээ. Өөрөөр хэлбэл бүх хэрэг маргаанд урьдчилсан хуралдаан явуулахгүй. Хэрэв нэхэмжлэлийн шаардлага нь тодорхой, талууд төдийлөн маргахгүй байгаа хэрэг маргаанд урьдчилсан хуралдааныг явуулах шаардлагагүй байж болно. Нөгөө талаар шүүгч хэрэг маргааныг үр нөлөөтэй удирдан явуулах үүднээс хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэж урьдчилсан хуралдаан явуулах эсэхийг шийдвэрлэх эрх хэмжээг олгожээ.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас урьдчилсан хуралдааныг хэргийн оролцогчийн хүсэлт, шүүгчийн санаачилгаар гэж заалгүйгээр заавал явуулах хэлбэрээр хуульчлах санал гаргаж байв. Процессын ажиллагааг зөвхөн шүүх удирдаж явуулж байгаа учраас хэргийн оролцогчийн хүсэлтээр гэвэл урьдчилсан хэлэлцүүлэг дахин дахин явагдах боломжтой болох, талууд урьдчилсан хуралдаан хийхгүй байх, улмаар урьдчилсан хуралдаангүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөтэй байдал буурах зэргээр шалтгаанаа тайлбарлаж байв. Түүнчлэн, урьдчилсан хуралдааныг хэд хэдэн удаа явуулж болох зохицуулалтыг шүүгчид эсэргүүцэж байсан. Хэрэв ингэж олон удаа хийж болохоор нээлттэй орхивол урьдчилсан хуралдааны үр нөлөө буурах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжрах, хурал хойшлох нөхцөл байдал бий болох эрсдэлтэй гэж үзэж байсан.

Урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа явуулах нь ямар ч үр дүнгүй, өмнөхөөсөө ялгаагүй зохицуулалт болно. Тиймээс урьдчилсан хэлэлцүүлгийг зохион байгуулах тоог 2 удаа хийнэ гэж тодорхой тусгах шаардлагатай. Урьдчилсан

хэлэлцүүлгийг хэлбэрийн төдий бус утгаар нь явуулах шаардлагатай. Анхнаасаа урьдчилсан хэлэлцүүлгийн зохион байгуулах практикыг тогтоочихвол цаашдаа хэрэгжихэд хялбар болчихно.

Урьдчилсан хэлэлцүүлэг хийх тоог хязгаарлах шаардлагатай. Эхний удаагийн хэлэлцүүлэгт хэргийн үйл баримттай холбоотой нотлох баримтуудыг гаргаж өгнө. Хоёр дахь удаагийн хэлэлцүүлгийг хэрэгт шинжээч, гэрч оролцуулах, шинээр нөхцөл байдал илэрсэн гэх мэт зайлшгүй тохиолдолд л хийхээр хязгаарлах нь зүйтэй. Маргаангүй байхад заавал хэлэлцүүлэг хийх шаардлагагүй учраас хоёр дахь удаагийн хэлэлцүүлгийг хийж болно гэж зохицуулах хэрэгтэй.

Уг урьдчилсан хэлэлцүүлгээр талуудын нотлох баримт гаргах хугацааг талууд нарийн зааглан тодорхойлж, шүүх түүнийг баталгаажуулна. Хэрэв талууд идэвхтэй оролцохгүй бол шүүх өөрөө тогтоохоос өөр аргагүй. Хоёр дахь удаагийн хэлэлцүүлэгийг хийх эсэхийг шүүх шийднэ гэдэг байдлаар оруулах.

Шүүгчидтэй хийсэн ярилцлагаас...

Дээрхээс дүгнэж үзвэл хуулийн төслийн 311-316 дугаар зүйлд заасан урьдчилсан хуралдаан явуулах заалтууд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай, үр нөлөөтэй явуулах зорилгодоо хүрэх боломжтой гэж дүгнэх боловч нөгөө талаар шүүгч нарын саналыг харгалзан үзэж урьдчилсан хуралдааны тоог хязгаарлах боломжийг судлах нь зохистой гэж үзэж байна.

337 дугаар зүйл. Хариуцагч хариу тайлбар ирүүлэлгүй шүүх хуралдаанд оролцох

337.1.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн ...-т заасан үүргээ биелүүлээгүй буюу хариу тайлбар ирүүлээгүй хэдий ч хэргийн бусад оролцогч шүүх хуралдаанд оролцож байгаа бол шүүх хуралдаан дээр тайлбар гаргаж болно.

337.2.Энэ хуулийн 337.1-т заасан тохиолдолд хэргийн бусад оролцогч шүүх хуралдаанд ирээгүй бол шүүх хуралдаан дээр тайлбар гаргах эрхгүй.

Хуулийн төслийн дээрх зохицуулалт нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, хариуцагчийг хариуцлагажуулах, бичгээр хариу тайлбараа ирүүлээгүйн үр дагаврыг тодорхой болгох замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах зорилготой байна.

Хуулийн төслийн 337 дугаар зүйлд хариуцагч хариу тайлбараа ирүүлэлгүй шүүх хуралдаанд оролцох тохиолдол болон түүний үр дагаврын талаар тусгажээ. Хуулийн төсөлд шинээр тусгагдаж, мөн амь орж буй зарчмын томоохон өөрчлөлт бол Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр явуулах, хуулийн төслийн 17.1 дүгээр зүйлд хариуцагч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэслэл болж буй үйл баримтын талаар тайлбар гаргах үүрэгтэй, 17.2 дугаар зүйлд хэргийн оролцогчийн тайлбарт дурдаагүй үйл баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохыг хориглох, хуулийн төслийн 19.1 дүгээр зүйлд хэргийн оролцогч шүүхээс тогтоосон хугацаанд хариу тайлбарын өөрчлөлт, нотолгооны хэрэгслийг хууль болон шүүхээс тогтоосон хугацаанаас хожимдуулан гаргасан тохиолдолд шүүх хүлээн авахгүй, хуулийн төслийн 327.2-т хариуцагч нэхэмжлэлийг гардан авсан боловч хариу тайлбар ирүүлээгүй бөгөөд шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож, энэ хуульд

заасан хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэж шүүгчийн захирамж гаргана гэсэн уялдаа холбоотой зохицуулалтуудаас үзвэл хариуцагч заавал хариу тайлбараа бичгээр гаргах үүрэгтэй байхаар хуулийн төслийн бусад зүйл заалттай уялдуулж өгсөн байна.

Хариу тайлбар гаргаж өгөх хугацааг хуулиар болон шүүхээс тогтоосоор байтал хариу тайлбараа бичгээр өгөх үүргээ биелүүлээгүй бол хуулийн төслийн 19.1-т зааснаар хариу тайлбарыг хүлээн авахгүй байж болох зохицуулсан заалттай зөрчилдөх байдлыг үүсгэхээр байна. Түүнчлэн, хуулийн төслөөр хариу тайлбараа бичгээр гаргаж өгөхийг шаардаж байгаа атлаа хариуцагч амаар тайлбар гаргаж болохоор зохицуулж өгсөн нь мөн зөрчил үүсгэх эрсдэлтэй. Мөн хариу тайлбараа урьдчилж бичгээр гаргаагүй байтал шүүх хуралдаан дээр амаар тайлбар гаргах нь нэхэмжлэгч талд гэнэтийн нөхцөл байдал бий болгох, шүүх хуралдаан дээр гаргасан аман тайлбарт тэр дор нь хариу тайлбар гаргах боломжгүй байх, бэлтгэлгүй байх, шүүх хуралдаан дээр амаар гаргасан тайлбарын эсрэг нотлох баримт бүрдүүлэх боломжийг хаах зэргээр мэтгэлцэх зарчим хэрэгжихгүй байх нөхцөл байдлыг үүсгэх, улмаар шүүх хуралдаан хойшлогдох шалтгаан нөхцөл болох боломжтой байна.

Тэр чигт хасах. Учир нь урьдчилсан хэлэлцүүлэгтэй зөрчилдөнө. Урьдчилсан хэлэлцүүлэгийг хийхгүй байх тохиолдолд л хэрэглэгдэх боломжтой. Гэвч энэ заалтын үндсэнд шүүх хуралдаанд тайлбар гаргана гэх боломжтой болох учраас урьдчилсан хэлэлцүүлгийг ач холбогдол байхгүй болно.

Сюрприз барихгүй гэсэн мэтгэлцэх зарчимтайгаа зөрчилдөнө. Бичгээр өгнө гэж үүрэгжүүлсэн заалттай зөрчилдөж байгаа учраас үүргээ биелүүлээгүй байх тохиолдолд амаар гаргахаар зохицуулж болохгүй. Хуулийн төслийн 337.2 байх боломжгүй. Шүүх хуралдаанд оролцож буй хэргийн оролцогчийг үг хэлүүлэх боломжоор нь хангахгүйгээр орхино гэдэг нь боломжгүй зүйл юм. Үндсэн хуульд заасан эрхийг нь хязгаарлаж болохгүй.

Хэргийн оролцогч давж заалдах болон хяналтын шатны шүүхэд тайлбар гаргах эрхгүй байдаг учраас амаар тайлбар гаргах эрхийг хязгаарлах нь эрсдэлтэй. Энэ нь шүүхэд мэдүүлэх эрхийг зөрчих эрсдэлтэй байна.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Иймд, хуулийн төслийн 337.1 болон 337.2 дугаар зүйл нь зорилгодоо хүрэх боломжгүй, хуулийн төслийн бусад зүйл заалттай зөрчилдсөн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим болох мэтгэлцэх зарчимтай зөрчилдөж байх тул бүхэлд нь хасах шаардлагатай байна.

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

1. Хуулийн төслийн 13 дугаар зүйл. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах зарчим

13.1. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй, үр нөлөөтэй байдлаар удирдан явуулна.

Одоогийн ИХШХШТХ-ийн 89.1-т “Шүүх хуралдааныг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилогдсон шүүгч даргална” гээд, 89.2-т “Шүүх хуралдаан даргалагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээг авна” гэж зааж өгсөн нь тухайн шүүх хуралдааныг даргалах агуулга болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах агуулгыг хамтад нь хуульчилж өгчээ. Гэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүх хуралдаан даргалагч хуулийн дагуу явуулах гэж тодорхойлсоноос биш хуулийн дагуу хэрхэн яаж явуулах талаар нарийвчлан тусгаж өгөөгүй байна. Өөрөөр хэлбэл, хуульд зааснаар буюу шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах эрх хэмжээг илүү хязгаарлагдмал шинжтэй, уян хатан бус байдлаар зохицуулж өгсөн нь харагдана.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн онцлог нь шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь удирдан явуулах талаар тусгаж, ингэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй, үр нөлөөтэй удирдан явуулах талаар хуульчилж өгсөн байна.

Онолын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах зарчим болон шүүх хуралдааныг удирдан явуулах зарчим агуулгын хувьд ялгаатай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах эрх гэдэг нь хэргийг түргэн шуурхай саадгүйгээр явуулахын тулд шүүхэд олгогдсон удирдах буюу даргалах эрх хэмжээг хэлэх ба нөгөө талаараа мөн үүрэгтэй.⁸ Тухайлбал, шүүх хуралдааныг товлон зарлах эрх, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх, шүүгчийн захирамж шийдвэр гаргах хэлбэрээр илрэн гарах бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагааг удирдан явуулах зарчим билээ. Харин шүүх хуралдааныг даргалах эрх нь шүүх хуралдааныг хуульд заасан процессын хэлбэрээр явуулах эрх хэмжээ юм.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд Тохирсон байх зарчмын талаар тусгаж өгсөн ба уг зарчмын агуулгыг “Шүүх хэргийн нарийн төвөгтэй байдал, ач холбогдол, шинж чанарыг харгалзан хянан шийдвэрлэх ажиллагааг харьцангуй байдлаар явуулна” гэж заажээ. Агуулгын хувьд хэргийн нөхцөл байдал, маргааны үйл баримтын ээдрээ төвөгтэй байдалд нь тохируулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулахдаа тухайн хэрэгтээ тохирсон байдлаар ажиллагааг удирдаж явуулах агуулга гэж ойлгогдож байна. Нөгөө талаар энэ агуулга нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй, үр нөлөөтэй байдлаар удирдан явуулж буй агуулгатай давхцсан байж болохоор байна.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас үзвэл “идэвхтэй, үр нөлөөтэй” гэдгийг хэрхэн ойлгох, тайлбарлах талаар тодруулах, агуулгыг нь ойлгомжтой болгох талаар саналаа хэлж байв.

Шүүх хэргийг үр нөлөөтэйгөөр удирдан явуулснаар хэргийг шийдвэрлэхэд илүү гүнзгий орж, бодит үнэнтэй нийцсэн шийдвэр гаргахад дөхөм болно.

Шүүх хэргийг нэгэнт шийдэж л байгаа юм чинь тодорхой хэмжээнд эрх хэмжээтэй байх ёстой. Одоогийн хуулиар шүүхийн эрх хэмжээг маш их хязгаарласан байдаг учраас шүүхийн нөхцөл байдал одоогийн энэ төвшинд хүрсэн. Тиймээс энэ зарчмын хүрээнд шүүхэд ийм эрх хэмжээг олгож байгаа нь

⁸伊藤真・伊藤塾『民事訴訟法【伊藤真の条文シリーズ⑦】（第1版）』248頁（弘文堂、2006年）

зүйтэй. Гэхдээ эргээд зарчмыг маш зөвөөр тайлбарлаж хэрэглэж явахгүй бол шүүх хөндлөнгийн байх зарчмаа алдсан гэж буруутгагдах эрсдэл бий болдог.

Энэ зарчмын үр дүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хурдан шуурхай явагдах боломж бүрдэнэ. Ингэхийн тулд хэргийн оролцогч нарын эрх, үүргийг хуульд нарийн тодорхой болгож, эрх зүйн үр дагаврыг тодорхой болгож өгөх хэрэгтэй.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Дээрхээс дүгнэж үзвэл хуулийн төслийн 13 дугаар зүйлд заасан Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй, үр нөлөөтэй удирдан явуулах зарчмыг шүүгч нар хүлээн зөвшөөрч байна. Харин энэхүү зарчмын агуулгыг илүү тодорхой болгох, найруулгын хувьд дахин нягтлах, хэргийн оролцогчийн эрх үүргийг илүү тодорхой болгож, эрх үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх эрх зүйн үр дагаврыг тодорхой болгох шаардлагатай.

2. Хуулийн төслийн 76-83 дугаар зүйл. Хамтран нэхэмжлэгч, хариуцагч

76 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох
77 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцоход бие даасан байх зарчим
78 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй бүгд хамтран оролцох
79 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй нэгдэж хамтран оролцох
80 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй хамтран оролцох журам
81 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамтран оролцох
82 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох талаар мэдэгдэх
83 дугаар зүйл. Хамтран оролцогч аль нэгийгээ төлөөлүүлэн оролцуулах

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШтХ-ийн 27 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн зохигч оролцох тухай буюу хамтран нэхэмжлэгч, хариуцагчийн талаарх ойлголтын талаар зохицуулсан байдаг. ИХШХШтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн нэхэмжлэгч буюу хэд хэдэн хариуцагч хамтран оролцож болно” гэж заасан бөгөөд энэ нь иргэний эрх зүйн харилцаанд хэд хэдэн үүрэг гүйцэтгүүлэгч, эсхүл үүрэг гүйцэтгэгч оролцох боломжтой байдагтай холбоотой.

Тухайн хамтран үүрэг гүйцэтгүүлэгч этгээдүүд нь шүүхэд нэхэмжлэлээ хэнд хандуулан, хэрхэн гаргах асуудлыг өөрсдөө л шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, үүрэг гүйцэтгүүлэгчид нь нэг эсвэл хэд хэдэн үүрэг гүйцэтгэгчид хандан нэхэмжлэл гаргах, мөн тус нэхэмжлэлээ хамтран эсхүл дангаараа гаргах эсэх нь тэдгээрийн өөрсдийн хүсэл зоригоос шалтгаалдаг. Шүүгч тухайн нэхэмжлэлийг хэн гаргасан байна түүнийг л нэхэмжлэгч гэж, хэнд холбогдуулж шаардлага тавьсан байна түүнийг л хариуцагч гэж үзнэ.⁹ Гагцхүү хамтран нэхэмжлэгч буюу хамтран хариуцагч нь нэг хүсэл сонирхолтой, ашиг сонирхлын зөрчилгүй этгээдүүд байх учиртай.

Хэрэв хамтран нэхэмжлэгч, эсхүл хамтран хариуцагч оролцож байгаа иргэний эрх

⁹ “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” УБ 2008 он., 97 дахь тал.

зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд бүгд оролцох шаардлагагүй бөгөөд энэ нь хэргийн шийдвэрт сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл тухайн хамтран нэхэмжлэгч, хариуцагч нар нь аль нэгийгээ төлөөлүүлэн оролцуулж болох ба энэ тухай ИХШХШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, эсхүл хариуцагчаар нэг этгээд оролцож байгаа боловч шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан, хариуцлагад хэд хэдэн этгээд татагдсан хэвээр байна.¹⁰

Мөн зүйлийн 27.3 дахь хэсэгт “Шаардлагатай гэж үзвэл шүүх шийдвэрээ гаргахаас өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр этгээдийг хамтран нэхэмжлэгч, буюу хамтран хариуцагчаар татан оролцуулж болно” гэж заажээ. Дээр дурьдсанчлан үүрэг гүйцэтгэгчид нь хэнд хандан хэрхэн шүүхэд нэхэмжлэл гаргах нь тэдгээрийн өөрсдийн хүсэл зоригоос хамаарна. Шүүхээс тухайн хэрэгт хамаарал бүхий этгээд нь хариуцагчид хандан шаардлага гаргахыг хүсээгүй байхад нэхэмжлэгч болгох, эсрэгээрээ нэхэмжлэгчийн хүсээгүй этгээдийг хамтран хариуцагчаар татан хариуцлага ногдуулах нь өөрөө учир дутагдалтай юм. Учир нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь диспозитив байх тусгай зарчимтай бөгөөд шүүх өөрийн үйл ажиллагаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг зөрчиж болохгүй.¹¹ Тодруулбал, хамтран нэхэмжлэгчээр хэн нэгнийг татан оролцуулахыг нэхэмжлэгч болон хамтран нэхэмжлэгчээр оролцох ёстой гэж шүүхийн үзэж буй этгээд өөрөө хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Түүнчлэн нэхэмжлэгч зөвшөөрсөн тохиолдолд л хамтран хариуцагчийг татан оролцуулж болно. Энэ байдлаар хэргийн оролцогчийн санаачилга, хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдсанаар иргэний процессын уг зарчим хэрэгжих боломжтой.

ИХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн Дөрөвдүгээр бүлгийн Гуравдугаар дэд бүлэгт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох” тухай зохицуулсан бөгөөд энэхүү дэд бүлэг нь 76-аас 83 дугаар зүйл хүртэлх 8 зүйлээс бүрдэнэ. Тус хуулийн төслийн зүйл заалтыг одоогийн хуультай хэлбэрийн хувьд харьцуулан үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох тодорхой тохиолдол бүхий нөхцөл, хэрэглэгдэх зарчим, процесст хэрхэн хэрэгжүүлэх журмыг илүү дэлгэрэнгүй зохицуулжээ.

Хуулийн төслийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах тохиолдолд хэд хэдэн нэхэмжлэгч, эсхүл хэд хэдэн хариуцагч хамтран оролцож болно” гээд 76.1.1, 76.1.2, 76.1.3 дахь заалтуудад хэд хэдэн нэхэмжлэгч хариуцагч хамтран оролцох тохиолдлыг тусгасан. Уг хуулийн төслийн агуулга нь Япон Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох тухай агуулгатай төсөөтэй болжээ. Япон улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах гурван тохиолдлыг аль нэг нь байх нөхцөлд хамтран оролцож болохоор заасан байдаг.

- Нэгдүгээрт, тухайн нэхэмжлэлийн зүйлийн хувьд эрх, үүрэг нь адил байх буюу нэг агуулга бүхий үүргийн харилцаа үүссэн байх тохиолдолд хэд хэдэн этгээд хамтран оролцож болно. Тухайлбал хэд хэдэн этгээдүүд газрын хамтран өмчлөгч байх тохиолдолд бусдын хууль бус эзэмшлээс газраа чөлөөлүүлэхээр хамтран шаардах эрх үүсэх бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч нь хамтран үүрэг гүйцэтгэгчдээс үүргийн гүйцэтгэлээ шаардах зэрэг нь энэ тохиолдолд хамаарна.
- Хоёрдугаарт, тухайн нэхэмжлэлийн зүйл нь нэг ижил үйл баримтын хүрээнд

¹⁰ Мөн тэнд.

¹¹ Ц.Амарсайхан, Ж.Амарсанаа нар “Процессын эрх зүй: Онол, туршлага” УБ 2014 он., 209 дэх тал.

үүссэн буюу нэг хууль зүйн үндэслэлтэй байх тохиолдолд хамтран оролцож болно. Тодруулбал, нэг удаагийн тохиолдлоор хэд хэдэн этгээдэд нэгэн зэрэг гэм хор учруулсан байх тохиолдолд хохирсон буюу эрх ашиг нь бусдын буруутай үйлдлээр хөндөгдсөн этгээдүүд хамтран хохирлоо шаардах боломжтой.

- Гуравдугаарт, нэхэмжлэлийн зүйл нь нэг төрлийн буюу үйл баримт, хууль зүйн нэг төрлийн үндэслэлтэй байх тохиолдлыг зохицуулжээ. Өмнөхөөс ялгаатай нь тухайн эрх зүйн маргаан нэг тохиолдолд зэрэг болсон үйл баримтаас биш, ижил төрлийн гэрээний үүргээс үүдсэн гэдгээрээ ялгагдана. Жишээлбэл, арилжаа эрхлэгч нь хэрэглэгчдээс өөрийн нийлүүлсэн барааныхаа үнийг шаардах нь хоорондоо хамааралгүй олон тохиолдол боловч худалдах худалдан авах гэрээний нэг төрлийн харилцааны үндсэнд олон тооны этгээдээс нэгэн зэрэг шаардах боломжтой гэж ойлгох нь зүйтэй юм.

Эндээс үзвэл дээрх гурван тохиолдлын нэгдүгээр тохиолдол нь олон этгээдүүд нийлэн нэг үүргийг хамтран буюу хувааж гүйцэтгэх, гүйцэтгүүлэх тухай ойлголтыг авч үзсэн бол харин хоёр болон гуравдугаар тохиолдол нь тус тусдаа үүргийн харилцаанд байх хэд хэдэн этгээдүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тухай ойлголтыг зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох болон хэд хэдэн этгээдүүд нийлэн оролцох тухай ойлголтууд нь хоорондоо эрх зүйн үр дагаварын хувьд ялгаатай байгаа юм.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШтХ-ийн 27 дугаар зүйл болон хуулийн төслийн 76 дугаар зүйл дэх зохицуулалтыг хооронд нь харьцуулан үзвэл хуулийн төсөлд дээрх ойлголтуудыг ялгаатай байдлаар тодорхойлж өгсөнөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн этгээдүүд оролцох, хамтран оролцох тухай процесс үр нөлөөтэйгөөр бодитой хэрэгжих боломжтой болжээ. Одоогийн хуулийн зохицуулалтаас харахад эдгээр ялгаатай ойлголтуудыг зааглан тодорхойлоогүйгээс практикт хэрэглэхэд зөрүү үүсч болзошгүй юм.

Хуулийн төслийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн оролцогч оролцох, хамтран оролцох тухай зохицуулалтыг үг зүй, найруулгын хувьд илүү ойлгомжтой байдлаар засан сайжруулах шаардлагатай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, дээрх ойлголтууд нь хоорондоо ялгаатай учраас ялгаж томъёолох шаардлагатай. Энэ байдлаараа практикт хэрэглэхэд ойлгомжгүй зохицуулалт болсон.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Мөн хуулийн төслийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт “Хамтран оролцогчийн аль нэгэнд үүссэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөхцөл байдал нь бусад хамтран оролцогчдод нөлөөлөхгүй” гэж заасан. Уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцоход бие даасан байх зарчим нь шүүх тухайн хэргийг хянан шийдвэрлэх нэгдмэл байдлыг хангадаг тогтолцоо биш бөгөөд тухайн этгээд нь өөрийн зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд дангаараа хандах эрхтэй гэх байдлаар тайлбарлагддаг.¹² Тэгвэл

¹² 伊藤真・伊藤塾『民事訴訟法【伊藤真の条文シリーズ⑦】（第1版）』74頁（弘文堂、2006年）

хуулийн төслийн 77.1-т “Хамтран оролцогчийн...” гэж заасан байх ба энэ заалтаас бие даасан байх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцоход үйлчлэх байдлаар ойлгогдож байна. Угтаа хамтран оролцох гэдэг нь нэг гэрээний үүргийг хамтран хариуцах тухай ойлголт учраас бие даасан байх зарчим энд хэрэгжих боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, хамтран оролцогчдын бие даасан байдлын зарчим нь хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцоход ч хэрэгжих боломжтой.

78 дугаар зүйлд Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй бүгд хамтран оролцох, 79 дүгээр зүйлд Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй нэгдэж хамтран оролцох тухай зохицуулсан байна. Төслийн энэ хэсгийн зохицуулалт нь ойлгомжгүй байдлаар томъёологдсоны улмаас хэрэгжих боломжгүй байх эрсдэлтэй байна.

3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

1. Хуулийн төслийн 11 дүгээр зүйл. Үл маргах зарчим

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь талуудын тохиролцоо буюу гэрээ гэх ойлголт байх бөгөөд талууд тухайлсан маргааны талаар тодорхой эрх зүйн үр дагавар үүсгэх нөхцөл байдлыг харилцан тохиролцож болдог байна. Тухайлбал, харьяаллын талаар тохиролцох, шүүх хуралдааны өдрийг талууд тохиролцож өөрчлөх, давж заалдах эрхийг хязгаарласан тохиролцоо болон арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх тохиролцоо зэрэг юм.

Харин Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, талууд процессын агуулгыг харилцан тохиролцож өөрчлөхийг хориглодог боловч иргэний процессын хууль дээр тодорхой зохицуулалт тусгаагүй процессын асуудлаар талууд тохиролцож болох уу гэх асуулт урган гарна. Энэ хүрээнд нэгдүгээрт, тухайн маргааныг шийдвэрлүүлэх эсэхээ өөрөө мэдэх эрх болон мэтгэлцэх зарчмын зүй зохистой хүрээнд, талуудын тухайн тохиролцоо нь хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагаанд ямар сөрөг үр дагавар үүсгэж болзошгүйг урьдчилан тооцоолсон тохиолдолд процессын хуульд тодорхой тусгаагүй асуудлаар талуудын тохиролцоог хүчин төгөлдөр гэж үзэж болдог байна.¹³ Өөрөөр хэлбэл, талуудын хүсэл зоригийг хүндэтгэх буюу тухайн тохиролцоо нь боломжит хүрээнд байх шаардлагатай бөгөөд тухайн тохиролцооны улмаас талуудад урьдчилан таамаглаагүй хохирол учруулахааргүй байх ёстой.

Одоогийн ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-т “...талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн гэрээг албадан гүйцэтгүүлэхээр бол ... нотариатын мэдэгдэх хуудас ... шүүхээр баталгаажсан байна.” гэж хуульчилсан. Мөн Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлд мэдэгдэх хуудасны агуулга, үүнд тавигдах шаардлагыг хуульчилж өгсөн.

Энэ нь талууд гэрээнд үл маргах байдлаар үүргээ гүйцэтгэх талаар тохиролцож, үүнийгээ нотариатаар гэрчлүүлж, шүүхээр баталгаажуулснаар шууд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдах боломжийг олгосон зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаар маргаан гарвал шүүхээр шийдвэрлүүлэлгүй, нотариатын мэдэгдэх хуудсыг шүүхээр баталгаажуулах замаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд шилжих

¹³ 伊藤真・伊藤塾『民事訴訟法【伊藤真の条文シリーズ⑦】（第1版）』247頁（弘文堂、2006年）

боломжтой. Гэхдээ шүүхийн практикт энэ заалтыг төдийлөн идэвхитэй хэрэглэхгүй байна. Учир нь иргэдийн эрх зүйн ухамсар төдийлөн сайн биш, гэрээгээ сайтар уншиж түүнээс үүдэн гарах эрх зүйн үр дагавар, өөрт үүсэх эрх үүргээ бүрэн ухамсарлаж ойлголгүйгээр гэрээнд гарын үсэг зурах, гэрээ нь гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөх зэрэг эрсдэлийг мөн дагуулж байдаг гэжээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд мөн дээрхтэй төстэй агуулгыг зарчим болгон тусгасан. Үл маргах журмаар гэрээний үүргээ биелүүлэхээр гэрээнд тусгаж нотариатаар гэрчлүүлснээр тухайн гэрээтэй холбоотой маргааныг шүүх хүлээн авахаас татгалзах нь талуудын шүүхэд мэдүүлэх эрхийг шууд хязгаарласан заалт байна. Түүнчлэн, 11 дүгээр зүйлийг дэлгэрүүлсэн, хэрхэн хэрэгжүүлэх талаарх бусад зохицуулалт хуулийн төсөлд байхгүй байх тул энэхүү заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал сул, практикт хэрэгжих боломжгүй байна.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас үзвэл энэ зүйлийг зарчмын хэмжээнд оруулж өгөх шаардлагатай эсэх, шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол хэрхэн яаж эрхээ хамгаалуулах процессын журамгүй, иргэний шүүхэд хандах эрхийг хязгаарласан, иргэдийн эрх зүйн мэдлэг боловсрол сул байгаа тохиолдолд хэрэгжих боломжгүй заалт гэж дүгнэж байна.

Үл маргах журмаар гэдэг үгийг нь батлаад байна уу, тогтолцоог нь батлаад байна уу, эсхүл гэрээг нь батлаад байна уу гэдгийг тодруулах шаардлагатай. Одоогийн гэрээнүүдийг харвал маргааныг үл маргах журмаар шийдвэрлэнэ гэсэн агуулга орсон байдаг. Энэ зарчмын дагуу үл маргах журмаар гэдэг үг орсон болгоныг татгалзаад байх уу, эсхүл нотариатч үл маргах журмын талаар талуудад тайлбарлаад баталгаажуулсаныг ойлгох уу гэдгийг тайлбарлаж зохицуулахгүй бол хэрэглээний тал дээр ойлгомжгүй байдал үүсэх эрсдэлтэй. Шүүхэд мэдүүлэх эрхийг шууд хязгаарлаж буй зарчим учраас талууд гэрээ байгуулахдаа эрх нь хязгаарлагдаж байгаа гэдгийг сайтар мэдэж байх ёстой.

Иргэдийн эрх зүйн ухамсар сул төвшинд байгаа учраас энэ зарчим хэрэглэгдэхэд хэцүү юм. Гэрээний эрх чөлөөний зарчим үйлчлэх үү гэдгийг бодох шаардлагатай. Гэрээнээс үүдэлтэй маргаан гарсан тохиолдолд хэрхэн хянан шийдвэрлэх вэ гэдэг асуудал яригдаж байгаа учраас зарчмын төвшинд биш нөхцөл болгож оруулах нь зүйтэй. Болж өгвөл мөнгөн дүн тавьж хязгаарлавал зүгээр. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгө барьцаалаад зээл өгсөн байх тохиолдолд нотариатын мэдэгдэх хуудас бичээд ороод ирвэл заавал шүүхийн шийдвэрээр албадан худалдах зохицуулалт бий. Тиймэрхүү байдлаар мөнгөн дүн тавьж, шалгуур тавьж өгөхгүй бол шууд энэ байдлаар нь хэрэглэхэд төвөгтэй байна.

Харин зарим шүүгчид нотариатч, аливаа гэрээ хэлцэл хийж буй этгээд хариуцлагатай байх ёстой учраас энэ заалт хэрэглэгдэх боломжтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл дагаж мөрдөх журмын тухай хууль, эсхүл Нотариатын тухай хуульдаа өөрчлөлт оруулах байдлаар хариуцгаажуулж болох юм. Нотариатын мэдэгдэх хуудсыг гэрээ байгуулж буй талуудад зөв тайлбарладаг, эргээд түүндээ

баталгаа гаргадаг, шүүхэд эрх үүрэг тайлбарласан баримтыг давхар гаргаж өгдөг байдлаар хуульд зохицуулалт хийвэл боломжтой гэж үзэж байна. Тэгэхгүй бол нотариатч гэрчилсэн гэрээнээс үүссэн маргаан болгоныг шүүх хүлээн авахаас татгалзаад байвал утгагүй.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Харин хоёр аж ахуй эрхлэгчийн хоорондын арилжааны гэрээ, хэлцэлд үл маргах журмыг хэрэглэх боломжтой байж болох юм. Тухайлбал, үл маргах журмаар барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах, үл маргах журмаар барьцаа хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх зэргээр тохиролцож гэрээнд тусгах боломжтой байна. Ингэхдээ жижиг хэмжээний арилжаа эрхлэгчид (эрх зүйн мэдлэг, засаглал сул тул) хамаарахгүй байдлаар зохицуулах нь зүйтэй байж болох юм. Иргэд хоорондын болон хэрэглэгчийн гэрээнд энэхүү процессын журмыг ашиглах нь тохиромжгүй байна.

Тиймээс, дээрх үндэслэлүүдээр хуулийн төслийн 11 дүгээр зүйлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй, практикт хэрэгжихгүй гэж дүгнэв.

2. Хуулийн төслийн 14 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч, шударгаар оролцох зарчим

14.1.Хэргийн оролцогч үнэнч, шударгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, эрхээ урвуулан ашиглахыг хориглоно.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч, шурдаргаар оролцох зарчмыг шинээр тусгаж өгсөн байна. Шүүхийн практикт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хойшилж буй нэг шалтгаан нь хэргийн оролцогч өөрт олгогдсон эрхээ урвуулан ашиглах байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах тохиолдол байна. Тухайлбал, Л.Т нарын нэхэмжлэлтэй Л.Г нарт холбогдох хэрэг зохигч, тэдгээрийн өмгөөлөгч нараас нотлох баримт гаргуулах, бүрдүүлэхээр 46 удаа, зохигчийн өмгөөлөгч хуралдаанд оролцох боломжгүй, шүүх хуралдаан давхцсан, эсхүл зохигч өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд оролцох хүсэлтээр 13 удаа, бусад үндэслэлээр 6 удаа, нийт 65 удаа шүүх хуралдаан хойшилсоор хэрэг хянан шийдвэрлэх хугацаа 1541 хоног буюу 4 жил гаруй хугацаагаар хэтэрсэн байна¹⁴. Энэ мэтчилэн шүүх хуралдааныг хойшлуулах зорилгоор, өмнө нь шүүхэд гаргах боломжтой байсан боловч шүүх хуралдаан болгон дээр ямар нэгэн хүсэлт гаргадаг, үүнийг нь шүүгч мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлж хэргийн оролцогчийн эрхийг хангах үүднээс хүсэлтийг хангаж шийдвэрлэж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах үндсэн шалтгаан юм.

Зүй нь шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдааныг хойшлуулахаар шийдвэрлэж байгаа бол оролцогчийн шүүх хуралдаанд гаргасан хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй байсан болон шүүх хуралдаан дээр гаргах хүндэтгэн үзэх шалтгааныг шалган тогтоож, энэ талаар захирамждаа тайлбарлаж тусгасан байх шаардлагатай. Тухайлбал, Япон улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нотлох баримт болон нотолгооны хэрэгсэлтэй холбоотой хүсэлтийг шүүхээс тогтоосон

¹⁴ http://www.supremecourt.mn/files/20220/0_1642583446.pdf 2023.12.08-ны өдөр үзсэн.

хугацаанд гаргаж өгөх шаардлагатай. Хэрэв тус хугацаанд гаргаагүй бөгөөд хугацаа хэтрүүлэн гаргаж байгаа тохиолдолд хэргийн нөгөө талд хүндэтгэн үзэх ямар шалтгаанаар заасан хугацаанд гаргаагүй талаар тодруулах эрхийг олгосон байх бөгөөд талуудыг мэтгэлцүүлж, хүндэтгэн үзэх шалтгааныг тодруулсаны дараа шүүх хүлээн авах эсэхийг шийдвэрлэдэг байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч шударгаар оролцох зарчмын талаар шүүгчид:

Хэргийн оролцогч гэсний араас *өмгөөлөгч* гэж оруулах нь зүйтэй. Өмгөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцуулах тухай үүрэгжүүлсэн, зарим эрхийг хориглосон заалт оруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, одоогийн хуулийн зохицуулалтаар хэргийн оролцогчид өмгөөлөгч хамаарахгүй байгаа тул, өмгөөлөгчид зориулсан хориглосон заалтыг оруулж өгөх шаардлагатай.

Хэргийн оролцогч нарын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх, үүргийг нарийн тодорхойлох шаардлагатай. Мөн үүргээ биелүүлээгүйгээс үүдэх үр дагавар, хариуцлагыг мөн тодорхойлох шаардлагатай.

Урвуулан ашиглах гэдгийг илүү дэлгэрүүлж тодруулах нь зүйтэй. Шүүхийн шийдвэр хүчингүй болгох нэг үндэслэл нь нэхэмжлэлийн үндэслэл шаардлага тодорхойгүй гэдэг. Зарим тохиолдолд хэргийн оролцогчид хэргийн үйл баримтыг шүүхэд өөр өөрөөр мэдүүлээд байдаг. Угтаа болсон үйл баримт нэг л агуулгатай, нэг л зүйл байдаг. Тиймээс энэ зарчим хэрэглэгдэх боломжтой.

Одоогийн хуулийн 25.1-ийн дагуу үнэнч шударгаар гэдэг агуулга байгаа. Үүн дээр нэмэгдэж буй нь эрхээ урвуулан ашиглах тухай ойлголт юм байна. Энэ агуулгыг илүү тодруулах нь зүйтэй болов уу.

Гарчигтаа хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч, шударгаар оролцоно гэж тодруулах шаардлагатай. Яг хэнд хамаарч буйг малгай гарчгаараа тодорхой байлгах шаардлагатай. Зарчим болгосноороо илүү ач холбогдолтой, үр нөлөөтэй ашиглагдах боломжтой.

Шүүчг нартай хийсэн ярилцлагаас...

Дээрхээс дүгнэж үзвэл хуулийн төслийн 14 дүгээр зүйл заасан Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч шударгаар оролцох зарчим хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй, ач холбогдолтой, хэрэгжихүйц заалт байна.

3. Хуулийн төслийн 15 дугаар зүйл. Тохирсон байх зарчим

15.1. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон байх зарчим баримтална. 15.2. Шүүх хэргийн нарийн төвөгтэй байдал, ач холбогдол, шинж чанарыг харгалзан хянан шийдвэрлэх ажиллагааг харьцангуй байдлаар явуулна.

15.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн үйлдэлд хариуцлага оногдуулахдаа үйлдэлдээ санаатай, эсхүл болгоомжгүй хандсан эсэх, хор уршгийн хэмжээ, цар хүрээ, ач холбогдлыг харгалзан үзнэ.

15.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нарийн төвөгтэй байдал, шинж чанар, маргааны цар хүрээнд тохирсон, харьцангуй байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон байх зарчим баримтлахаар тусгажээ. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх процессын ажиллагааг шүүгч удирдан явуулах, ингэхдээ идэвхитэй үр нөлөөтэй удирдан явуулах талаар хуулийн төслийн 13 дугаар зүйлд тусгаж өгсөн ба энэ зарчмаас ямар ялгаатай болох, ялгаатай бол агуулгыг илүү тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.

Хуулийн төслийн 15.2-т “шүүх хэргийн төвөгтэй байдал, ач холбогдол, шинж чанарыг харгалзан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг харьцангуй байдлаар явуулна” гэж байгаа боловч ямар асуудлаар харьцангуй хандах талаар тодорхойлж өгөхгүй бол ойлгомжгүй зохицуулалт болжээ. Энэ заалтын талаар шүүгчид дараах байдлаар шүүмжилж байв.

Энэ заалтын гарчгийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэргийн нөхцөл байдалд тохирсон байх зарчим” гэж өөрчлөх нь зүйтэй.

Энэ заалтын “ач холбогдол” гэсэн үг үсгийг хасах, “шинж чанар” гэдгийг “хэргийн нөхцөл байдал, ээдрээ төвөгтэй байдал” зэргээр сольж найруулах.

Энэ хэсэгт зардлын тухай зохицуулах нь тохиромжгүй. Зардал бол тусдаа зохицуулалттай байх шаардлагатай.

Хэргийн оролцогчийн хувьд тухайн мөнгөн дүн их бага байх, шүүгчийн хувьд их бага байх нь ялгаатай ойлголт учраас тохирсон байх зарчим хэрэглэх тохиолдолд шүүх маргааныг хянан шийдвэрлэх процесс нь өөрөө ялгамжтай байж тэрэнд нь тохирсон байх гэдэг агуулгаар оруулах шаардлагатай. Яг энэ байдлаараа зохицуулаад явбал шүүх урьдчилаад шийдвэрээ гаргасан гэж буруутгагдах эрсдэл үүсч болох юм. Одоо ч гэсэн маргаан байхгүй хэргийг хурдан шуурхай шийдвэрлээд болж байгаа. Заавал ингэж оруулж ирэх нь юугаараа давуу талтай болж байгаа вэ?

Шүүхэд хандсан зарчим гэж ойлгогдож байна. Энэ зарчмын томъёолол, зорилго нь тодорхойгүй байна. Яг юунд тохирсон байх гэдэг нь ойлгомжгүй байна. Зарчим гэдэг нь тухайн этгээдийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгож буй зүйл. Гэвч энэ зүйлийн 15.3 дахь хэсэгт хариуцлага оногдуулахдаа үйлдэлдээ, 15.4 дэх хэсэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нь гэх мэтээр томъёолж зохицуулсанаас харахад тохирсон байх зарчмын гол санаа нь яг юу вэ гэдэг нь ойлгомжгүй байна.

Дээрхээс дүгнэн үзвэл хуулийн төслийн 15 дугаар зүйл ойлгомжгүй томъёологдсон, хүлээн зөвшөөрөгдөх байдал султай байна. Иймд хуулийн төслийн 15 дугаар зүйлийг төслийн 13 дугаар зүйлтэй нэгтгэх, уялдуулж тайлбарлах, ямар асуудлаар тохирсон байх буюу уян хатан хандах талаар тодорхой тусгаж өгөх шаардлагатай гэж дүнгэв.

4. Хуулийн төслийн 17 дугаар зүйл. Тайлбар гаргах үүрэг

17.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэслэл болж байгаа үйл баримтын талаар тайлбар гаргах үүрэгтэй.

17.2.Хэргийн оролцогчийн тайлбарт дурдаагүй үйл баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохыг хориглоно.

17.3.Хэргийн материал болон илэрхий дурдаагүй асуудал.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.1-т “ хэргийн оролцогч шүүхэд үнэн зөв тайлбар гаргах” үүрэгтэй, 25.2.2-т “шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримт цуглуулах, гаргаж өгөх”, 38.1-т “ зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй” , 72.2-т “хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй” хэмээн тайлбар гаргах үүргийн талаар хуульчилж өгсөн байдаг.

Хуулийн төслийн 17.2-т хэргийн оролцогчийн тайлбарт дурдаагүй үйл баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохыг хориглож өгсөн нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, талуудын гаргаж өгсөн нотлох баримт болон тайлбарын хүрээгээр хязгаарлах замаар мэтгэлцэх зарчмыг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлж, шүүгч хөндлөнгийн байж хэрэг маргааныг хянан шийдвэрлэх зорилготой байна.

Мэтгэлцэх зарчмын нэг гол агуулга бол шүүх нь талуудын тайлбартаа дурдаагүй үйл баримтад үндэслэн шүүх хуралдааныг явуулж болохгүй юм. Үүнийг талуудын үүднээс авч үзвэл, өөрт ашигтай үйл баримтыг тайлбартаа дурдаж нотлох шаардлагатай. Хэрэв талууд тухайн үйл баримтын талаар тайлбар гаргаж мэтгэлцээгүй байхад нотлох баримтаас тухайн үйл баримт тодорхой болсон байсан ч тухайн үйл баримтыг болоогүй мэтээр авч үзнэ¹⁵. Учир нь тухайн үйл баримтын талаар тайлбартаа дурдаагүй учраас шүүгч хөндлөнгийн байж, талуудыг мэтгэлцүүлэх үүднээс нэг талд нь гэнэтийн нөхцөл байдлыг бий болгож болохгүй юм. Энэ талаар шүүгч нар дараах байдлаар саналаа хэлж байв:

Хуулийн төслийн 17.1 болон 17.2-т заавал бичгээр гэж оруулах шаардлагатай. Бичгээр гэж оруулахгүй бол аман хэлбэрээр тайлбар гаргахын сөрөг үр дагавар нь талуудын мэтгэлцэх зарчим хэрэгжихэд саад учруулна. Өөрөөр хэлбэл, хурал

¹⁵ 伊藤真・伊藤塾『民事訴訟法【伊藤真の条文シリーズ⑦】（第1版）』140頁（弘文堂、2006年）

болгон дээр өөр өөр үйл баримт ярьдаг нь нөгөө талдаа сюрприз барих, мэтгэлцэх боломжийг нь хязгаарлаж байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн маргаан дээр миний эд хөрөнгийг багаар үнэлсэн гэж маргадаг. Тухайн хөрөнгийн өмчлөгчөөс үнийн санал авалгүйгээр шинжээч томилсон байдаг. Өөрөөр хэлбэл, процесс ажиллагаанд дунд нь нэг алдаа гаргавал түүнээс хойш тухайн ажиллагаа хүчингүй болно. Гэвч хуулийн төслийн энэ заалтаас харвал шүүх тухайн алдааг мэдсээр байж хүчингүй болгож чадахгүй нөхцөл байдалд хүрэхээр байна.

Хуулийн төслийн 17.1 дэх заалт дээр бичгээр гэж үүрэгжүүлж нэмэх шаардлагатай. Мөн зарим тохиолдолд бичгээр тайлбараа өгчихөөд шүүх хурал дээр өөр зүйл ярих тохиолдол гардаг. Үүнтэй уялдан бичгээр гаргаагүй үндэслэлээр маргах эрхгүй гэдэг байдлаар зохицуулах нь зүйтэй. Хэрэв шинэ юм ярих бол тогтоосон хугацааны дотор ярих ёстой гэдэг байдлаар үүрэгжүүлэх шаардлагатай. Талуудаас эцсийн тайлбарыг хүлээж авах зарчмыг журамлах шаардлагатай.

Тайлбарыг заавал өгөх үүрэгтэй гэж зохицуулах нь зүйтэй. Хугацаандаа тайлбарыг өгөхгүй бол шүүх хэргийг шууд шийдвэрлэнэ гэсэн заалтыг амь оруулж байна. Энэ тайлбар өгөх үүргийг бичгээр гэж зохицуулбал практикт хэрэглэхэд илүү хялбар болно. Аливаа зүйлийг бичгээр авахын ач холбогдол нь талуудын аль аль нь мэдэж буй зүйлийн хүрээнд бие биедээ сюрприз барихгүйгээр мэтгэлцэхэд оршино.

Хэргийн оролцогчид янз бүрийн эрх зүйн мэдлэгтэй байдаг. Тайлбар гаргах нь хэргийн оролцогчдын үүрэг мөртлөө үүнийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй гэхээр агуулгын хувьд хоорондоо зөрчилдөж байна. Тэгэхээр энэ заалт байх шаардлагагүй. Аль эсвэл Шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй гэж зохицуулсанаас хэргийн оролцогч бичгээр дурьдаагүй үйл баримтын хүрээнд шүүх хуралдаанд мэтгэлцэхгүй гэх маягаар зохицуулах нь зүйтэй.

Шүүчг нартай хийсэн ярилцлагаас...

Дээрхээс дүгнэж үзвэл шүүгчдийн хэлж буй саналтай судалгааны багийн санал нийлж байгаа бөгөөд мэтгэлцэх зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 17 дугаар зүйлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжтой байна.

5. Хуулийн төслийн 18 дугаар зүйл. Нотлох үүрэг

-
- 18.1.Хэргийн оролцогч өөрт ашигтай үйл баримтыг өөрөө нотлох үүрэг хүлээнэ.
 - 18.2.Нотлох үүргийг материаллаг хуулийн дагуу хуваарилна.
 - 18.3.Шүүхийн санаачилгаар нотлох баримт цуглуулахыг хориглоно.
-

ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.1-т “ хэргийн оролцогч шүүхэд үнэн зөв тайлбар гаргах” үүрэгтэй, 25.2.2-т “шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримт цуглуулах, гаргаж өгөх”, 38.1-т “ зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаархи нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй” , 72.2-т “хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй” хэмээн тайлбар гаргах үүрэг болон нотлох баримт гаргаж өгөх үүргийн талаар хуульчилж өгсөн байдаг.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1-ийн нотлох үүрэг одоо ч агуулгаараа ИХШХШТХ-д тусгагдсан гэж үзэж болно. Харин хуулийн төслийн 18.2 дахь хэсгийн хувьд шинэ зохицуулалт орж ирсэн байна. Процессын хуулийн дагуу нэхэмжлэгч нэхэмжлэлийн үндэслэл болон түүнийг нотлох баримтаа, хариуцагч татгалзал болон татгалзлыг нотлох баримтаа шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй. Материаллаг эрх зүйн хувьд нотлох үүргийн шилжилт, хуваарилалт хийгдэж байдаг.

Шүүгч ч гэсэн хүн учраас нэхэмжлэгч болон хариуцагчийн хэнийх нь үнэн зөв болохыг ялгахад төвөгтэй нөхцөл байдалтай тулгарна. Энэ тохиолдолд шүүгч хэргийг шийдвэрлэх нь зайлшгүй бөгөөд шийдвэрээ гаргахаас өөр аргагүй. Тиймээс хийсвэр байдлаар талуудын аль нэг нь хэргийн үйл баримтыг нотолж чадахгүй бол маргаанд ялагдах эрсдэлтэй талаар материаллаг хуульд тусгаж, үүнийг нотлох үүргийн хуваарилалт гэдэг байна.¹⁶ Үндсэндээ нэхэмжлэгч талд буюу шаардах эрхтэй гэж үзэж байгаа тал нь нотлох үүргийг хүлээдэг. Тухайлбал, ослын улмаас хохирсон этгээд нь осол болсон талаар, ослын улмаас хохирол учирсан талаар, осол болон хохирлын хооронд шалтгаант холбоотой болох талаар нотлох шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, хохирогчид нотлох үүргийг хүлээлгэсэн байна.

Түүнчлэн, үүргийн харилцаа дуусгавар болсон талаар эрхийг үгүйсгэж байгаа тал нь энэ талаар нотлох үүргийг хүлээж байдаг. Тухайлбал, мөнгө зээлсэн боловч буцаан төлсөн гэж маргаж байгаа бол мөнгө зээлсэн тал нь зээлсэн мөнгөө буцаан төлсөн талаарх үйл баримтыг нотлох шаардлагатай бол мөнгө зээлдүүлсэн хүний хувьд зээлийн эргэн төлөлтийг хүлээн аваагүй гэдгээ нотлох шаардлагатай юм. Товчоор дүгнэвэл, өөрт ашигтай үйл баримтыг нотолсноор өөртөө ашигтай нөхцөл байдлыг бий болгож байгаа тал нь нотлох үүгийг хүлээх юм. Гэхдээ материаллаг хуулиар зарим тохиолдолд, нотлох үүргийг шилжүүлж, дүрмийн бус тохиолдол үүсгэх нь бий. Тухайлбал Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” гэж хуульчилж өгсөн байна. Хүний нэр төрд гэм хор учруулсан тохиолдолд нэхэмжлэгч тал нотлох үүрэгтэй гэхээс илүүтэй хариуцагч тал өөрийн тараасан мэдээг үнэн зөвийг нотлох үүргийг хуулиар хүлээлгэж байгаа нь нотлох үүргийг хариуцагч талд шилжүүлж байгаа хэлбэр юм. Хуулийн төслийн 18.2-т заасан нотлох үүргийн хуваарилалтын талаар шүүгчид төдийлөн нэгдсэн ойлголтгүй байсан болно.

¹⁶ https://www.yokohama-roadlaw.com/glossary/cat2/post_186.html

Материаллаг хуулийн дагуу гэх нь ойлгомжгүй томьёолол байна. Үүний оронд тайлбар, татгалзал гэж одоогийн хуулийн үг үсгээр зохицуулбал Монголын хөрсөнд илүү ойлгомжтойгоор бууна. Одоогийн байгаа үндсэн зарчим санаанд өөр агуулга оруулах хэрэггүй гэсэн саналтай байна.

Одоогийн хууль нь субъектив нотлох үүргийг хуваарилалт явагдаж байгаа. Гэвч материаллаг хуулийн буюу объектив нотлох үүргийн хуваарилалт байх шаардлагатай.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Судалгааны багийн зүгээс хуулийн төслийн 18.2 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц, байх ёстой заалт гэж үзэж байна. Учир нь нотлох үүргийн хуваарилалтын дагуу өөрт ашигтай үйл баримтыг нотолж чадсанаар өөрт ашигтай эрх зүйн үр дагавар бий болгохоор хүсч байгаа тал нь нотлох үүрэгтэй байхаар зааж өгөх нь маргааны зүйлийг тодорхойлох, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах бүрдүүлэхэд ач холбогдолтой байна.

Хуулийн төслийн 18.3-т “шүүхийн санаачилгаар нотлох баримт цуглуулахыг хориглоно” гэж зааж өгсөн байна. Энэ нь мэтгэлцэх зарчмыг сонгодог утгаар нь бүрэн дүүрэн хэрэгжүүлэх зорилготой байна. Одоо мөрдөгдөж буй ИХШХШтХ-ийн 38 дугаар зүйлийн 38.9-т “Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах...” талаар хуульчилж өгсөн байдаг. Энэ нь мэтгэлцэх зарчимтай тодорхой хэмжээнд зөрчилдөөнийг үүсгэж байдаг. Мэтгэлцэх зарчмын нэг гол агуулга бол шүүх хөндлөнгийн байж гагцхүү талуудын гаргаж өгсөн нотлох баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэх байдаг. Хэрэв шүүгч өөрийн санаачилгаар шинээр нотлох баримт шаардаж байгаа нь хэргийн оролцогчийн нэг талд давуу байдал олгох¹⁷ эрсдэлийг бий болгож байдаг.

Гэтэл нөгөө талаар, шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагатай бөгөөд талуудын хувьд шүүгчийн гаргаж байгаа шийдвэр шударга ёсонд нийцсэн байх шаардлагатай, хүлээн зөвшөөрөгдөхүйц байх шаардлагатай юм. Үүнд тулгарч буй гол асуудал нь хэргийн оролцогчийн эрх зүйн мэдлэг ухамсар төдийлөн сайн хөгжөөгүйн улмаас өөрт зайлшгүй шаардлагатай нотлох баримтаа гаргаж мэдэхгүй байх асуудал үүсдэг байна. Энэ талаар шүүгчид:

Одоогийн нөхцөл байдалд хэрэгжихэд хүндрэлтэй. Энэ зарчмыг хэрэгжүүлэх тохиолдолд зөвхөн арилжааны харилцаанд гэж зааглах нь зүйтэй. Учир нь иргэд, олон нийтийн эрх зүйн боловсрол харилцан адилгүй төвшинд байдаг. Тиймээс яг ямар харилцаанд хэрэглэхийг зааглаж тодруулах шаардлагатай.

Энэ бол талуудын цэвэр мэтгэлцэх зарчмыг оруулж ирж байгаа юм байна. Одоо манай хуульд яг ямар зарчим байна. Манай иргэд ийм эрх зүйн боловсролтой

¹⁷ Т.Бадрах, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” <https://legaldata.mn/buteel/pdf?id=942>

байна. Талуудын мэтгэлцээн дээр үндэслээд явбал цаана нь шударга ёсны зарчим хөндөгдөнө. Учир нь шүүхийн шийдвэр үнэн бодит байдалд нийцсэн, үндэслэл бүхий байх ёстой. Гэтэл үүнтэй зөрчилдөх гээд байна. Тодорхой ажиллагаанууд дээр л шүүгч нотлох баримт бүрдүүлэх хэмжээнд оролцож болно. Хэрэв цэвэр талуудын мэтгэлцэх зарчимтай болно гэвэл магадгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход заавал хуульчтай оролцох шаардлага үүснэ. Гэвч хүн бүрт хуульчид төлөх санхүүгийн боломж бололцоо байхгүй.

ИХШХШТХ-ийн 38.9 хуульд шалгууртайгаар байх ёстой. Учир нь талуудын зарчмаас илүүтэйгээр шүүх хэргийг үндэслэлтэй, бодит үнэнд нийцсэн байдлаар шийдвэрлэх ёстой. Улсын Дээд Шүүхийн гаргасан тайлбарын хүрээнд ашиглагдах ёстой.

Эрх зүйн боловсрол муутай улс оронд шүүх яг байгаагаар нь хөндлөнгөөс оролцохгүй талуудын зарчимд үндэслээд хэргийг шийднэ гэвэл түүн шиг амархан зүйл байхгүй. Гэвч эрх зүйн мэдлэг дутмаг, өмгөөлөгч авахад санхүүгийн бололцоогүй хүмүүс өөрт ашигтай нотлох баримтаа шүүхэд гаргаагүйгээс болоод эрх ашиг нь зөрчигдөх гээд байна. Тэгэхээр хэргийн оролцогч өөрт ашигтай үйл баримтыг өөрөө нотлох үүрэг хүлээнэ гэж зохицуулж байгаа бол эрх ашиг нь хөндөгдөх гээд байгаа тэр хэсэг бүлэг хүмүүсийн эрхийг хамгаалах гарц бас байх ёстой.

ИХШХШТХ-ийн 38.9-ийг хэрэглэх боломжтой байхад хэрэглээгүй гэх шалтгаанаар шүүхийн шийдвэрүүд хүчингүй болох тохиолдол байдаг. Ингэж зохицуулах нь шүүгчдэд амар болгож байна.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас

Дээрхээс дүгнэж үзвэл шүүгчид хуваагдмал байр суурьтай байгаа нь харагдана. Гэхдээ хуулийн төслийн 18.3-аар шүүгчийн санаачилгаар нотлох баримт бүрдүүлэхийг хориглож байгаа нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, шүүгч хөндлөнгийн байх зармыг хэрэгжүүлэх нэг хөшүүрэг болох нь гарцаагүй. Гэхдээ иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар сайн хөгжөөгүй өнөөгийн нөхцөлд буюу шүүгчид бүх зүйлийг даатгах байдлаар хандах, түүнчлэн зайлшгүй ялах, нэхэмжлэлийн шаардлагаа хангуулах маргаанд өөрт ашигтай нотлох баримтаа гаргаагүй, аль эсвэл гаргаж мэдэхгүйн улмаас нэхэмжлэлийн шаардлагаа хангуулж чадаагүй бол үүний үр дагавар нь шүүхэд итгэх итгэлийг унагах эрсдэлтэй юм. Товчоор хэлбэл шүүгч хэргийг шударгаар шийдвэрлээгүй гэх нэр зүүх юм.

Япон Улсын хувьд дээрх асуудлыг даван гарахын тулд шүүгчийн тодруулах эрх болон үүргийг¹⁸ иргэний процессын хуульдаа хуульчилж өгсөн байна. Тодруулах эрхийн агуулга нь хэргийн нөхцөл байдлыг тодорхой болгохын тулд хэргийн үйл баримт болон эрх

¹⁸ Япон Улсын Иргэний процессын хуулийн 149 дүгээр зүйл.

зүйн асуудлын талаар талуудаас тодруулах асуулт асууж, мөн нотолгоо шаардах замаар хэрэгжүүлэх шүүгчийн эрх хэмжээг хэлдэг байна¹⁹. Шүүгчийн тодруулах эрхийг мэтгэлцэх зарчмыг засварлаж, сул талыг нь нөхөх зорилготой гэж үзэн дэмждэг байна.

Шүүгчийн тодруулах эрхийн хүрээ хязгаарыг тогтоож өгөхгүй бол мэтгэлцэх зарчимтай зөрчил үүсгэх тул дараах байдлаар тодруулах эрхийн хүрээг тогтоож өгчээ. Нэгдүгээрт, хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэх үүднээс мэтгэлцэх зарчмын алдааг засах байдлаар, талуудын гаргаж өгсөн нотлох баримт тодорхой бус, хангалттай бус тохиолдолд шүүгч тодруулах эрхээ хэрэгжүүлэх замаар тэдгээрийн талаар дурдах, шаардлагатай арга хэмжээ авахыг шаардах байдлаар илрэн гардаг. Хоёрдугаарт, хоёр талын нотлох баримт цуглуулах тэгш эрхийг хангах үүднээс шүүгчийн тодруулах эрхийг хэрэглэх, гуравдугаарт тодруулах эрхийн зорилго нь талуудыг хангалттай мэтгэлцүүлэх зорилготой энэ үүднээс тодруулах эрхийг хэрэгжүүлэх талаар дурджээ.²⁰

Шүүгчийн тодруулах эрхийн тухайд идэвхитэй болон идэвхигүй хэлбэрээр илрэн гардаг. Идэвхигүй хэлбэрээр гэдэг нь тухайлбал, талууд хэргийн талаар шаардлагатай хүсэлт болон тайлбар гаргаж байгаа боловч тэр нь тодорхойгүй аль эсвэл хоорондоо зөрчилтэй тохиолдолд шүүгч үүнийг тодруулах байдлаар илэрдэг. Идэвхитэй хэлбэрээр гэдэг нь талууд хэргийн талаар шаардлагатай хүсэлт болон тайлбар хийхгүй байгаа тохиолдолд энэ талаар шүүгч санал гаргах, онцлон заах зэргээр тодруулах эрхийг хэрэгжүүлдэг байна.²¹ Ингэхдээ шүүгч тодруулах эрхийг талуудад тэгш хандах байдлаар хэтрүүлж хэрэглэхгүй байх нь чухал байна. Үүнээс товч дүгнэвэл шүүгчийн тодруулах эрхийг шүүгч өөрийн санаачилгаар хийх хэдий ч захирамжилсан шинжгүй болох нь харагдаж байна.

Түүнчлэн, тодруулах эрх шүүгчид байгаа бол нөгөө талд тодруулах үүрэг мөн шүүгчид байх ёстой гэж тайлбарладаг байна. Тухайлбал, тодруулах үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас анхан шатны шүүхийн шийдвэр дээд шатанд хүчингүй болох мөн түүнчлэн давж заалдах гомдол гаргах үндэслэл ч болдог байна. Тодруулах үүргийн хүрээ хязгаарын тухайд, хэрэв идэвхигүй хэлбэрээр тодруулах эрхээ шүүгч хэрэгжүүлээгүй бол анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болдог²² бол идэвхитэй хэлбэрээр тодруулах эрхээ хэрэгжүүлээгүй бол хавтаст хэрэгт цугларсан бүх баримтыг үнэлж үзээд маргаанд ялах байсан тал ялаагүй, хэрэв шүүгч тодруулах үүргээ хэрэгжүүлсэн бол үр дүн нь өөр байх байсан бол, мөн талуудын эрх зүйн чадвар болон хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэргийг харгалзан үзээд талууд шаардлагатай хүсэлт, тайлбар, нотлох баримтыг шүүгчийн тодруулах эрхгүйгээр гаргах боломжгүй гэж дүгнэсэн тохиолдлоор л хязгаарлаж, дээд шатны шүүхээс тайлбарлан хэрэглэх ёстой байдаг байна.

¹⁹ 積極的釈明と釈明権行使の限界について中央大学学術リポジトリ <https://chuo-u.repo.nii.ac.jp/record/11111/files>

²⁰ 積極的釈明と釈明権行使の限界について中央大学学術リポジトリ <https://chuo-u.repo.nii.ac.jp/record/11111/files>

²¹ 伊藤真・伊藤塾『民事訴訟法【伊藤真の条文シリーズ⑦】（第1版）』249頁（弘文堂、2006年）

²² Япон Улсын Иргэний процессын хуулийн 325 дугаар зүйлийн 325.1 дэх хэсэг.

Дээрхээс дүгнэж үзвэл, манай шүүхийн практикт ч мөн нэхэмжлэлийн шаардлага тодорхойгүй, тодруулаагүй, аль эвэл зайлшгүй шаардлагатай нотлох баримт хэрэгт авагдаагүй үндэслэлээр давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгон буцаах тохиолдол гарч байна.

Иймд, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх үүднээс шүүгчийн санаачилгаар нотлох баримт бүрдүүлэх зохицуулалт болох ИХШХШТХ-ийн 38.9 дэх заалтыг халж, хуулийн төслийн 18.3 -т заасныг дэмжиж, түүнчлэн шүүгчийн тодруулах эрх болон үүргийн талаарх тодорхой зохицуулалт хуулийн төсөлд нэмж тусгах шаардлагатай байж болохоор байна. Шүүгчийн тодруулах эрх болон үүрэг нь шүүхийн практик шаардлагаас, өнөөгийн иргэдийн эрх зүйн боловсрол ухамсрын төвшинг харгалзан үзсэнч, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг сайжруулах зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан бий болгох шаардлагатай зохицуулалт байна.

6. Хуулийн төслийн 21 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр болон амаар явуулах

21.1.Хэргийн оролцогч нэхэмжлэл, хариу тайлбар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хүсэлт, гомдлоо бичгээр гаргана.

21.2.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдааны үед шүүгчийн зөвшөөрлөөр нэхэмжлэл, хариу тайлбарт оруулах өөрчлөлт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хүсэлт, гомдлоо амаар гаргаж болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулна...” гэж зааж өгчээ. Түүнчлэн, шүүхэд нэхэмжлэлийг бичгээр гаргах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөсөө татгалзаж байгаа бол бичгээр мэдэгдэх, зохигч бичгээр тайлбар өгөх, өмгөөлөгчийн эрхийг бичгээр баталгаажуулах, төлөөлөгч өмгөөлөгчийн эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэх бол бичгээр хүсэлтээ гаргах, хялбаршуулсан журмаар хэргээ шийдвэрлүүлж байгаа бол бичгээр эвлэрлийн гэрээ, хүсэлтээ гаргах талаар хуульчилж өгчээ. Үүнээс дүгнэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлтийг заавал бичгээр гаргах агуулга хуульд тусгагдаагүй байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1-т нэхэмжлэл, хариу тайлбар, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хүсэлт, гомдлоо бичгээр гаргахаар хуульчилж өгсөн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгэн хэлбэрт шилжүүлэхийг зорилго болгосон байна. Шүүхийн практикт талуудаас гаргасан хүсэлтийг амаар сонсоод, давхар бичгээр гаргаж өгөхийг шүүгч шаарддаг. Гэвч шүүх хуралдаан дээр гаргасан хүсэлтийг бичгээр гаргахгүй байсан ч болдог. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бүхий л хүсэлт, ажиллагааг бичгээр явуулах нь дараах байдлаар ач холбогдолтой. Үүнд²³:

1. Ээдрээ төвөгтэй, олон хүсэлт гаргаж байгаа бол хүсэлтийн тодорхой байдлыг хангах үүднээс бичгээр хүсэлт гаргах нь ач холбогдолтой.
2. Хэргийн ээдрээ төвөгтэй үйл баримт, эрх зүйн урьдчилсан нөхцөл, эрх зүйн дүн шинжилгээний талаар бичгээр тайлбар авах нь ач холбогдолтой.

²³ 伊藤真・伊藤塾『民事訴訟法【伊藤真の条文シリーズ⑦】（第1版）』146頁（弘文堂、2006年）

3. Урьдчилсан хуралдааныг хааж, хэргийн үйл баримт, хэрэгт цугларсан нотлох баримтыг цэгцлэхэд ач холбогдолтой байдаг.
4. Шүүхийн шийдвэр бичихэд бичгээр явагдсан ажиллагаа, тайлбарууд ач холбогдолтой байдаг.

Дээрхээс дүгнэн үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бүхий л хүсэлт, тайлбарыг бичгээр явуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой байдлыг бий болгох, нотлох баримт бий болгох, шүүгч шийдвэрээ боловсруулахад, хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтын хэмжээнд шийдвэрээ гаргахад ач холбогдолтой дээр, хамгийн чухал нь мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэхийн тулд шүүх хуралдаан дээр өмнө нь огт бичгээр болон амаар дурдаагүй үйл баримтын талаар мэтгэлцэж, хэргийн нөгөө талд гэнэтийн нөхцөл байдлыг бий болгох, мэтгэлцэх боломжийг нь хаахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой байна. Улмаар талуудын гаргасан хэргийн үйл баримтын талаарх тайлбарыг л шүүх шийдвэртээ дурдаж болохоос биш, талуудын тайлбартаа дурдаагүй шинэ үйл баримтад тулгуурлан шийдвэрээ гаргаж, үндэслэж болохгүй юм. Энэ талаар шүүгчид дараах байдлаар саналаа хэлж байв.Үүнд:

Хүсэлт, гомдлыг амаар гаргаж болно гээд харин нэхэмжлэл, тайлбар зэргийг бичгээр гаргана гэж зааглах нь зүйтэй. Учир нь хариу тайлбар, нэхэмжлэлийн шаардлагаа ихэсгэх багасгах, үндэслэлээ өөрчлөх зэрэг нь цэвэр мэтгэлцээнд суурилан явагддаг учраас эдгээрийг заавал бичгээр гаргана гэж үүрэгжүүлэх шаардлагатай. Харин хүсэлт, гомдол нь мэтгэлцээнд төдийлөн хамаардаггүй учраас амаар гаргаж болно гэж зохицуулах хэрэгтэй. Бүх юмаа бичгээр явуулна. Амаар явуулах тохиолдол нь байна гэж тусгайлах нь зүйтэй. Гэхдээ уг амаар гаргаж буй хүсэлт, гомдлыг зөвхөн урьдчилсан хэлэлцүүлгийн үед гаргах байдлаар зохицуулах нь тохиромжтой.

Урьдчилан хэлэлцүүлэг дээрх хүсэлт, гомдлын талаар хэлэлцэх учраас шүүх хуралдааны үед гэснийг хасах шаардлагатай. Тэгэхгүй бол урьчилсан хэлэлцүүлэг явуулсаны ач холбогдол байхгүй болно.

Шүүх хурлын үед амаар маш олон тодорхойгүй хүсэлт гаргах тохиолдол байдаг. Угтаа шүүгч бичгээр гаргасан хүсэлтийг уншиж судлаад шийдвэр гаргах шаардлагатай байдаг. Бичгээр гаргаагүйгээс үүдэн хүсэлтийг дутуу шийдвэрлэх тохиолдлууд байдаг. Тиймээс бичгээр бүх хүсэлт, гомдол, тайлбар зэргийг гаргах нь зүйтэй. Амаар гаргачихаад давж заалдах шатны шүүхэд “ингэж хэлээгүй” гэж маргадаг.

Шүүх хуралдаан дээр өмнө нь бичгээр гаргасан зүйлээ л дэмжиж амаар ярина. Тэрнээс биш бичгээр гаргаагүй бол амаар ярихгүй. Амаар гаргах нь шүүх хуралдааныг хойшлуулах гол үндэслэл болдог.

Хуулийн төслийн 21.2 нь бичгээр гаргана гэж үүрэгжүүлсэний гэдгийн эсрэг заалт болох магадлалтай. Шүүгчийн зөвшөөрлөөр гэж шүүхэд эрх олгож буй мэт боловч шүүгч үүнийг хориглож чадахгүй. Тиймээс амаар гэдгийг хасах шаардлагатай.

Хуулийн төслийн 21.2 дахь хэсэгт шүүх хуралдааны үед шүүгчийн зөвшөөрлөөр гэх шаардлагагүй. Учир нь урьдчилсан хэлэлцүүлэгийн зорилго нь ХХША-г хурдасгаж, урьдчилсан хэлэлцүүлгээр л бүх хүсэлт гомдолтой холбоотой зүйлсээ дуусгахад оршиж байгаа. Тиймээс шүүх хуралдааны үед хүсэлт гомдол гаргах нь хоорондоо зөрчилдөж байна.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Дээрхээс дүгнэж үзвэл хуулийн төслийн 21 дүгээр зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй, практикт хэрэгжихүйц зохицуулалт байна. Харин хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2-г найруулгын хувьд өөрчлөн найруулах шаардлагатай байж болохоор байна.

7. 251-264 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичиг хүргүүлэх

251 дүгээр зүйл.Шүүх өөрийн санаачилгаар баримт бичиг хүргүүлэх
252 дугаар зүйл.Баримт бичиг хүргэх этгээд
253 дугаар зүйл.Шүүгчийн туслах баримт бичиг хүргэх
254 дүгээр зүйл.Баримт бичгийг гардуулах
255 дугаар зүйл.Баримт бичгийг гардуулахтай холбоотой онцгой тохиолдол
256 дугаар зүйл.Баримт бичиг хүргэх газар
257 дугаар зүйл.Баримт бичиг хүргүүлэх газраа мэдэгдэх үүрэг
258 дугаар зүйл.Баримт бичгийг уулзсан газарт гардуулах
259 дүгээр зүйл.Баримт бичгийг хамааралтай этгээдэд хүргэх болон үлдээгээд явах
260 дугаар зүйл.Хилийн чандад баримт бичиг хүргэх
261 дүгээр зүйл.Баримт бичиг хүргэснийг баталгаажуулах
262 дугаар зүйл.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэх
263 дугаар зүйл.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэх арга
264 дүгээр зүйл.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэснээр үүсэх үр дагавар

Аль ч салбар эрх зүйн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчид аливаа баримт бичгийг гардуулах, тэдгээрийг шүүхэд дуудан ирүүлэх тухай ойлголт нь цаашид тухайн ажиллагаа хэрхэн явагдах үндсийг тодорхойлдог учраас ихээхэн ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл, хариуцагчийг шүүхэд дуудан ирүүлэх, нэхэмжлэлийн хувийг гардуулах зэрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан хугацааны дотор явагдах эсэхтэй шууд холбоо хамааралтай.

Одоогийн ИХШХШтХ-ийн 72 дугаар зүйлд нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах, 77 дугаар зүйлд шүүхийн мэдэгдэх хуудас хүргүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан. Харин ИХШХШтХ-ийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд энэ тухай 251 дүгээр зүйлээс 264 дүгээр зүйл хүртэл “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичиг хүргүүлэх” гэх нэгэн дэд бүлэг болгон зохицуулжээ.

Шүүхийн мэдэгдэх хуудас нь шүүхээс тодорхой этгээдэд хүргүүлж буй албан ёсны баримт бичиг юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд дуудан ирүүлэх шаардлагатай бүхий л тохиолдолд хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдыг шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудаж ирүүлнэ. Үндсэндээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

оролцогч шүүхийн дуудсанаар өөрөө ирж аливаа баримт бичигтэй танилцах, тухайн баримт бичгийг гардан авах үүрэгтэй байдаг.

Харин хуулийн төслийн 251 дүгээр зүйлд шүүх аливаа баримт бичгийг өөрийн санаачилгаар хэргийн оролцогчдод хүргэх үүрэгтэй байхаар тусгажээ. Бодит байдал дээр шүүх хөндлөнгийн этгээд учраас баримт бичгийг хүргэх үүрэг хүлээх ёсгүй бөгөөд үүнтэй холбоотой санаачилгыг мөн адил гаргахгүй. Гагцхүү шүүх нь хэргийн оролцогч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх боломжгүй хуулиар хүлээсэн “төрийн” үүргийг л гүйцэтгэх ёстой.

Шүүхэд хүрэлцэн ирж баримт бичигтэй танилцаж, гарган авах тухай хэргийн оролцогчийн үүргийг шүүхийн үүрэг мэтээр хооронд нь ялгаагүй ерөнхий байдлаар хуулийн төсөлд тусгасан нь учир дутагдалтай байна. Тийм учраас энэ хэсэгт яг ямар баримт бичгийг шүүх хэргийн оролцогчдод хүргүүлэх вэ гэдгийг нарийвчлан тодорхой байдлаар тусгах шаардлагатай байна.

Мөн одоогийн хуулиас ялгаатай нь хуулийн төслийн 262 дугаар зүйлд нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэх гэх агуулга орсон бөгөөд хэргийн оролцогчийн хаяг мэдэгдэхгүй байгаа, баримт бичгийг хуулийн төслийн 259.1-д заасны дагуу үлдээгээд явсан боловч хүргэгдээгүй мөн хилийн чанадад баримт бичиг хүргүүлсэн боловч хүргэгдээгүй тохиолдолд нийтэд мэдээллээд тодорхой хугацааны дараа баримт бичиг хүргэгдсэнд тооцохоор заасан байна. Энэ нь нэг талаараа шүүх дуудан ирүүлэхээр мэдэгдсээр байхад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулдаг этгээдүүдийн үйлдлийг хязгаарлах зорилготой боловч нөгөө талаасаа хүний эрх, хувь хүний нууцтай холбоотой асуудал хөндөгдөх эрсдэлтэй байна.

Шүүгчидтэй ярилцлага хийхэд энэхүү нийтэд мэдээлэх байдлаар баримт бичиг хүргүүлэх арга нь практикт хэрэгжихэд хүндрэлтэй гэж үзсэн. Үүний учир нь одоогийн нийгмийн амьдралын болоод эрх зүйн ухамсарын түвшин тийм ч өндөр хөгжөөгүй байгаатай холбоотой. Мөн өнөөгийн нийгмийн байдлаар Монгол хүн өөрийн хаяг дээрээ амьдрахгүй байх олон тохиолдол байдаг гэж тайлбарласан юм. Үүний оронд улсын бүртгэлийн тогтолцоогоо сайжруулах замаар тухайн этгээд бүртгүүлсэн хаяг дээрээ байгаа эсэх, өөр хаяг руу нүүсэн байх тохиолдолд бүртгэлжүүлдэг байдлаар сайжруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, асуудалтай байгаа нийгмийн бусад хүчин зүйлсээ шийдэж чадвал заавал нийтэд мэдээлэх аргыг ашиглахгүй байх боломжтой гэх саналыг хэлж байв.

Нийтэд мэдээлэх замаар баримт бичгийг хэргийн оролцогчдод хүргэх аргыг хэрэгжүүлдэг улс орнууд байдаг ба үүний дотроос Япон улсын хуулийн зохицуулалттай манай улсын хуулийн төслийн агуулга төсөөтэй болжээ. Японы Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлд нийтэд мэдээлэх аргын тухай зохицуулсан бөгөөд хуулийн тайлбарт энэ нь хамгийн эцсийн арга байхаар заасан байна.²⁴ Эндээс үзвэл нийтэд мэдээлэх аргыг хуульд оруулах шаардлагатай гэж үзвэл хэрэглэгдэх хүрээг нь ихээхэн хумигдмал байдлаар тусгах нь зүйтэй. Хувийн эрх зүйн маргаанд оролцогч нь шүүхийн аливаа баримт бичиг, нөгөө талын нэхэмжлэл, тайлбарыг хүлээн авах, танилцах хүсэлгүй буюу “зөнд нь орхиж зайлсхийх” ч бодолтой байж болох тул зайлшгүй тохиолдолд л энэ аргыг хэрэглэх аргыг баримтлах нь зүйтэй.²⁵ Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогч шүүхэд хаягийн мэдээллээ өгөхгүй, эргэх холбоогүй, зайлсхийсэн хандлагатай байгаа нь тухайн этгээдийн хүсэл зориг учраас шүүх иргэн, хуулийн этгээдийн хувийн мэдээллийг олон

²⁴ 伊藤真・伊藤塾『民事訴訟法【伊藤真の条文シリーズ⑦】（第1版）』74頁（弘文堂、2006年）

²⁵ Шүүгчдийн ярилцлагаас

нийтэд цацсанаас илүү баримт бичгийг гардуулалгүй, тэдгээрийн оролцоогүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нь эрсдэл багатай байж болох юм.

Эндээс дүгнэхэд нэгдүгээрт, хуулийн төсөлд буй ойлгомжгүй, ерөнхий байдлаар тусгасан заалтуудыг нарийвчлан томёолох, үг зүй найруулгын хувьд ойлгомжтой байдлаар тусгах, хоёрдугаарт, өнөөгийн Монголын хөрсөнд тухайн зохицуулалт буух эсэхийг нягталж тодорхой хүрээнд хэрэгжих байдлаар хэмжээ хязгаартай зохицуулах шаардлагатай. Эс бөгөөс эсрэгээрээ сөрөг үр дагавар бий болох эрсдэлтэй байна.

8. 327 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль нэг нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар

327.1.Хэргийн оролцогч шүүх хуралдаанд ирээгүй, эсхүл хүрэлцэн ирсэн хэдий ч хэргийн талаар мэтгэлцээгүй бол шүүх тухайн этгээдийн гаргасан нэхэмжлэл, хариу тайлбар, нэмэлт тайлбартаа дурдсан тайлбарыг шүүх хуралдаанд гаргасан гэж үзэж, шүүх хуралдаанд ирсэн хэргийн бусад оролцогчийг мэтгэлцүүлнэ.

327.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардан авсан боловч хариу тайлбар ирүүлээгүй бөгөөд шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож, энэ хуульд заасан хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэж шүүгчийн захирамж гаргана.

327.3.Хариуцагчид нэхэмжлэлийг нийтэд мэдээлэх замаар гардуулсанд тооцсон бөгөөд шүүх хуралдаан ирээгүй тохиолдолд шүүх нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон бусад баримт нотолгоог үндэслэн хэргийг хянан шийдвэрлэнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нарыг бүрэн хамруулах нь хэргийн үйл баримтыг бүрэн тодорхойлох, талуудыг мэтгэлцэх боломжоор тэгш хангах ач холбогдолтой. Шүүхийн зүгээс талуудыг оролцох боломжоор бүрэн хангах, оролцогч нар хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд заавал оролцох үүргийг хуулиар хүлээсэн. Гэвч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудаас оролцохгүй байх тохиолдол түгээмэл гарч, хүдэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүйн улмаас хүлээх эрх зүйн үр дагавар, хариуцлага харьцангуй сул байгаа билээ.

Хуулийн төслийн 327 дугаар зүйлийн 327.1 дэх хэсэгт нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэг нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол шүүх хэргийг шийдвэрлэхээр тусгаж өгчээ. Харин нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаах зохицуулалтыг (ИХШХШТХ-ийн 100.2) хассан байна.

Шүүх нь хэрэг маргааныг хуульд нийцүүлэн үнэн зөв, шударгаар шийдвэрлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ хэрэгжүүлэх хүрээнд талуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүх хуралдаанд биечлэн оролцох, мэтгэлцэх боломжийг олгох нь хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой. Харин шүүх хуралдаанд хэргийн оролцогч нарыг заавал оролцуулах нь зорилго биш юм. Өөрөөр хэлбэл талуудыг шүүх хуралдаанд оролцох болон хуульд заасан эрхээ эдлэх боломжоор хангасан, нотлох баримт хангалттай бүрдсэн бол нэхэмжлэгчийн эзгүйд хэргийг шийдвэрлэх боломжтой байх нь зохимжтой.

Нэхэмжлэгч шүүх хуралдаанд өөрийн биеэр болон итгэмжлэлээрээ дамжуулан оролцож нэхэмжлэл, нотлох баримтыг тайлбарлан мэтгэлцэх нь нэхэмжлэл хангагдах магадлалыг нэмэгдүүлэх ач холбогдолтой боловч нэхэмжлэгч энэхүү эрхээ хэрэгжүүлэхгүй байх эрхтэй. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч өөрийн үндэслэлээ баримтаар хангалттай нотлогдоно гэж дүгнэж шүүх хуралдаанд оролцохгүй байх нь мөн түүний эрхийн асуудал юм.

Одоогийн ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.1-д зааснаар нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй бөгөөд өөрийн эзгүйд шүүх хуралдааныг хийх талаар хүсэлт ирүүлээгүй бол шүүхээс нэхэмжлэлийг буцааж байна. Жишээлбэл, 2022 онд Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 106 нэхэмжлэл, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 128 нэхэмжлэлийг тус тус буцаан шийдвэрлэсэн нь нэхэмжлэгч тал шүүх хуралдаанд хүрэлцэн ирэх үүргээ биелүүлээгүй байгааг харуулна.

Хуулийн төслөөр иргэний хэрэг нэгэнт үүсээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдсан бол хэргийн эцэслэн шийдвэрлэх зорилгыг агуулсан байна. Учир нь өмнө дурдсанчлан нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр нэхэмжлэлийг буцаадаг зохицуулалтыг халсан байна. Нэхэмжлэлийг буцаасны эрх зүйн үр дагавар нь улсын тэмдэгтийн хураамж улсын орлогод үлдэх боловч нэхэмжлэгч нэхэмжлэлээ дахин гаргах эрх нь нээлттэй үлддэг. Улмаар нэхэмжлэгч дахин нэхэмжлэлээ шүүхэд гаргаснаар өмнө нь шүүхээс хийсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудыг дахин эхнээс нь хийх шаардлагатай болдог нь шүүгчийн ажлын ачаалалд сөргөөр нөлөөлөх юм. Түүнчлэн, нэхэмжлэгч тал зориуд эрхээ урвуулан ашиглах замаар хэн нэгнийг шүүхэд дуудах, залхаах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргаад шүүх хуралдаанд ирэлгүйгээр буцаалгах, аль эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах зорилгоор шүүх хуралдаанд ирэлгүй буцаалгаад дахин нэхэмжлэл гаргах тохиолдол мөн байна. Тухайлбал, шүүгч нартай хийсэн ярилцлагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой маргаанд энэ нөхцөл байдал ажиглагддаг байна.

Нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйн эрх зүйн үр дагаврын талаар шүүгчид дараах байдлаар саналаа илэрхийлж байв. Үүнд:

-ИХШХШТХ-ийн 100.2 болон 106.3-ийн агуулга заавал байх ёстой.

-Шүүхэд төвөг удах, одоо хэргээ шийдвэрлүүлэхгүй ч дараа нь шийдвэрлүүлэх хүсэлтэй хүмүүс байдаг.

-Хуулийн төслийн 327.2 практикт хэрэглэгдэх боломжтой, хүлээн зөвшөөрч байна. Энд эрх үүргийг хангалттай тайлбарлаж өгсөн гэдгээ нотлох шаардлагатай болно.

-Хуулийн төслийн 327.3 дахь заалт практикт хэрэглэх боломжгүй. Нэхэмжлэлийн хувийг нийтэд мэдээллэх замаар гардуулан түүнийг ирээгүйд хэргийг хянан шийдвэрлэх тохиолдол байж болохгүй. Хариуцагч өөрт нь холбогдуулж нэхэмжлэл гаргасан гэдгийг мэдээгүй байхад нэг мэдэхэд хариуцлага хүлээх, төлбөр төлөх нөхцөл байдалд хүрч болзошгүй. Тиймээс энэ заалтыг хасах шаардлагатай.

-327.2 дахь заалт нь хүний давж заалдах гомдол гаргах эрхийг хязгаарлах эрсдэлтэй.

-Нэг удаа хойшлуулах нь зүйтэй. Тэгэхгүй бол шууд нэхэмжлэлийг буцаахаар эргээд л нэхэмжлээд ороод ирдэг. Өмнө хийсэн ажиллагаагаа дахиад л хийх болдог. Тиймээс ер нь хойшлуулж байгаад тухайн хэргээ шийдсэн нь л зүйтэй.

-Шүүхээс нэхэмжлэгчид шүүх хуралдааны товыг хуулийн дагуу мэдэгдэж, шүүх хуралдаанд оролцох эрхийг мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр

шүүх хуралдаанд ирэхгүй байгаа нь нэхэмжлэлээ дэмжихгүй байгааг харуулна. Нэхэмжлэлээ дэмжихгүй байгаа энэ байдлыг үндэслэн нэхэмжлэлийг буцаах нь нэхэмжлэгчийг идэвхжүүлэх, хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх ач холбогдолтой.

Шүүгчидтэй хийсэн ярилцлагаас...

Дээрхээс дүгнэж үзэхэд хуулийн төслийн 327.1 дэх хэсгийг шүүгчид хүлээн зөвшөөрч байгаа боловч, зарим шүүгчид нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүй бол нэхэмжлэлийг буцаах зохицуулалтыг хэвээр байлгах саналтай байсан бол зарим шүүгчид нэхэмжлэлийг буцаасан ч дахиад нэхэмжлэл ороод ирэх учраас нэг мөр шийдэх нь зүйтэй гэсэн хуваагдмал байр суурьтай байв. Судалгааны багийн зүгээс нэгэнт иргэний хэрэг үүсээд, шүүхээс тодорхой ажиллагаа хийсэн, нотлох баримт, тайлбар бүрдсэн, шүүхээс тодорхой зардал гарсан байгаа учраас хэргийг нэг мөр шийдэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь шүүхийн ажлын ачаалалд эерэг нөлөөтэйн дээр хэн нэг этгээд өөрт олгогдсон эрхээ урвуулан ашиглах замаар хэн нэгнийг шүүхэд дуудах, залхаан цээрлүүлэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Хуулийн төслийн 327.2 дахь хэсэг нь хүлээн зөвшөөрөгдөх заалт байна. Одоо мөрдөгдөж буй хуулийн 72.3-т энэ агуулга туссан байдаг боловч шүүхийн практикт төдийлөн хэрэглэдэггүй. Энэ заалтыг амь оруулахын тулд хэргийн оролцогчийн эзгүйд хэргийг шийдвэрлэж шийдвэр гаргах бус хялбаршуулсан журмаар шийдвэрлэж давж заалдах эрхийг нь хааж өгөх замаар хариуцагчийг хариуцлагажуулж байна. Хуулийн төслийн 327.2-г хэрэглэх урьдчилсан нөхцөл нь хариуцагч хариу тайлбараа ирүүлээгүй, шүүх хуралдаанд ирээгүй гэх 2 урьдчилсан нөхцөл зэрэг хангагдаж байж хэрэглэгдэх тул энэ үүргээ биелүүлээгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнтэй адилтгаж үзэх боломжтой юм.

Хуулийн төслийн 327.3 дахь хэсгийг шүүгчид хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь нийтэд мэдээлэх замаар нэхэмжлэлийг гардуулах арга зам нь хаягжилт тодорхойгүй, хаягийн шилжилт хөдөлгөөнийг хуульд заасан хугацаанд хийлгэж чадахгүй байгаа, түүнчлэн нүүдлийн мал аж ахуйтай өнөөгийн манай нөхцөлд тохиромжгүй тул практикт хэрэгжих боломжгүй, хүний нэр төрд халдах эрсдлийг бий болгох тул хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж дүгнэж байна.

9. 328 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль аль нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар

328.1.Хэргийн оролцогчийн аль аль нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэдгээрийн эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл шүүх хуралдааныг хойшлуулна.

Хуулийн төслийн 328 дугаар зүйлд нэхэмжлэгч хариуцагч нарын хэн аль нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тохиолдолд шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэдгээрийн эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл шүүх хуралдааныг хойшлуулахаар тусгажээ. Хэдийгээр нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй нь нэхэмжлэлээ дэмжихгүй байгааг харуулах боловч хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжтой байх нь шударга ёсны зарчимд нийцнэ. Иймд нэгэнт иргэний хэрэг үүссэн, шүүхээс хэргийг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байгаа тохиолдолд хойшлуулахгүйгээр эцэслэн шийдвэрлэх нь ач холбогдолтой юм.

Хойшлуулна гэхийн оронд нотлох баримтын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэнэ гэсэн нь зүгээр. Учир нь урьдчилсан хуралдааны үндсэнд хэргийг хянан шийдвэрлэх нотлох баримт хангалттай бүрдчихсэн байна.

Хүлээн зөвшөөрөх боломжтой зохицуулалт байна. Одоогийн хуулийн 100.4, 100.5-д заасантай ижил агуулгатай зохицуулалт юм.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Дээрхээс дүгнэж үзвэл хуулийн төслийн 328 дугаар зүйл нь одоо хэрэгжиж байгаа хуулийн 100.4 болон 100.5-д заасантай ижил агуулга бүхий зохицуулалт байх боловч шүүх хуралдааныг хойшлуулах гэсэн эрх зүйн үр дагавар үүсгэхээрээ ялгаатай. Хуулийн төсөлд зааснаар урьдчилсан хуралдааны үе шатыг бий болгож байгаатай холбоотойгоор урьдчилсан хуралдаанд маргааны үйл баримт тодорхой болохын зэрэгцээ, үүнд чиглэсэн тайлбар, нотлох баримтууд энэ үе шатанд тодорхой болсон байх учраас нэхэмжлэгч хариуцагч аль аль нь шүүх хуралдаанд ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулалгүй шууд шийдвэрлэх боломжтой юм.

Иймд хуулийн төслийн 328 дугаар зүйлээс “эсхүл шүүх хуралдааныг хойшлуулна” гэсэн агуулгыг хасах нь зүйтэй.

10. 329 дүгээр зүйл. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар

329.1. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд хүрэлцэн ирж чадаагүй бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан хугацааны дотор шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, эсхүл хойшлуулах боломжгүй бол хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн хэргийг хянан хэлэлцэнэ.

329.2. Хариуцагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд хүрэлцэн ирж чадаагүй тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан хугацааны дотор шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, эсхүл хойшлуулах боломжгүй бол хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн хэргийг хянан хэлэлцэнэ.

329.3. Хэргийн оролцогчийн эзгүйд хэргийг хянан шийдвэрлэх тохиолдолд түүний өмнө нь бичгээр гаргасан тайлбарыг шүүх хуралдаан дээр гаргасантай адилтгаж үзнэ.

329.4. Хэргийг оролцогчийн эзгүйд хянан хэлэлцсэн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Одоо хэрэгжиж буй хуулийн зохицуулалтаар нэхэмжлэгч, хариуцагч аль аль нь хүндэтгэн үзэх шалтгаантайгаар шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол хэдэн ч удаа шүүх хуралдааныг хойшлуулж болохоор эрх зүйн зохицуулалттай байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, сунжруулах зэрэг үр нөлөөгүй байдлыг бий болгоно.

Хуулийн төслийн зорилго нь бүхэлдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай, үр нөлөөтэй явуулахад чиглэгдэж байгаа. Энэ ч үүднээс нэхэмжлэгч, хариуцагч болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаантайгаар шүүх хуралдаанд ирээгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрээгүй байвал 1 удаа хуралдааныг хойшлуулж болохоор зохицуулж өгсөн байна. Энэ нь хүндэтгэн үзэх шалтгаантайгаар хэдэн ч удаа шүүх хуралдааныг хойшлуулах боломжийг хязгаарласанаар ач холбогдолтой байна. Харин “хойшлуулах боломжгүй бол хэрэгт авагдсан нотлох

баримтад үндэслэн хэргийг хянан хэлэлцэнэ” гэж заасны “хойшлуулах боломжгүй” гэдэг нь ойлгомжгүй томъёолол болжээ. “Хойшлуулах боломжгүй” гэдгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа дууссан гэж ойлгох, аль эсвэл шүүгч хойшлуулах боломжгүй гэж өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй байна. Шүүгч нар хуулийн төслийн энэ заалтын талаар:

Нэхэмжлэгчийн хүсэлтээр 1, Хариуцагчийн хүсэлтээр 1 удаа хойшлуулж болно. Хойшлуулахгүй боломжгүй бол гэдэг нь ХХША-ны хугацаа дуусах гээд байвал хойшлуулахгүй гэсэн санаа байна.

Одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээх саналтай байна. Мөн хуулийн төслийн 329.1, 329.2-ийг нэгтгэх.

Бичгээр гаргасан тайлбарын хүрээнд л шүүхэд мэтгэлцэх учраас шүүх хуралдаанд ирээгүй байсан ч шаардлагаа дэмжиж байгаа гэсэн үг. Тиймээс урьдчилсан хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цугларсан байх учраас одоогийн хуулийн дагуу хэргийн шийдэх боломжтой.

Хуулийн нэр томёо, бичилт, үг үсгийн найруулга сонин байна. Дахин дахин нэг хүсэлтээр олон удаа хойшлуулахгүй гэдэг хязгаарлалтыг бусад өөр заалтуудтайгаа уялдаж байгаа эсэхийг шалгах.

Эсхүл хойшлуулах боломжгүй бол гэдэг нь бас эргэлзээтэй энийг хэн тодорхойлох вэ, үүний оронд үндэслэлгүй бол гэсэн нь зүйтэй.

Шүүгч шүүх хуралдааныг хойшлуулах нөхцөл байдал бас үүсдэг. Жишээ нь шүүгч шүүх хуралдаан товлогдсон өдөр өвдөх тохиолдолд хойшлуулахаас өөр аргагүйд хүрдэг. Тиймээс энд шүүгчийн талаас хойшлуулах үндэслэлийг бас оруулж өгөх шаардлагатай.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Дээрхээс үзвэл хуулийн төслийн 329 дүгээр зүйл нь бүхэлдээ хүлээн зөвшөөрөгдөх байдалтай байна. Харин төслийн 329.1 болон 329.2-ыг нэгтгэн нэг зүйл болгон өөрчлөн найруулах боломжтой байна.

11. 338 дугаар зүйл. Хэргийн оролцогч бичгээр гаргасан тайлбартаа дурдаагүй үйл баримтын талаар шүүх хуралдаанд тайлбар гаргах

338.1.Хэргийн бусад оролцогч шүүх хуралдаанд ирээгүй бол хэргийн оролцогч шүүх хуралдаанаас өмнө нь гаргасан нэхэмжлэл, хариу тайлбар, нэмэлт тайлбартаа дурдаагүй үйл баримтын талаар шүүх хуралдаан дээр тайлбар гаргах эрхгүй.

Хуулийн төслийн 338 дугаар зүйлийн гол зорилго нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх байна. Мэтгэлцэх зарчмыг тодорхойлох 3 үндсэн ойлголтоос бүрдэнэ. Эдгээр ойлголтууд нь чиг үүргийн болон техникийн шинжийг агуулах бөгөөд нарийвчлан үзвэл гэнэтийн

дайралтаас урьдчилан сэргийлэх болон процессын баталгааг талуудад олгож, мэтгэлцэх эрхийг нь хангаж байдаг. Үүнд:

Нэгдүгээрт, талуудын мэдүүлээгүй, тайлбартаа дурдаагүй үйл баримт нь нотлох баримт шинжлэн судалсны үр дүнд тодорхой болсонч шүүгч үүнийг хүлээн зөвшөөрч болохгүй бөгөөд нотлох баримтаар ашиглахгүй. Хоёрдугаарт, шүүх талуудын хооронд маргаагүй үйл баримтын талаар нотлох баримт шинжлэн судлах шаардлагагүйгээр шүүхийн шийдвэрийн үндэслэлд дурдах ёстой. Гуравдугаарт, шүүх талуудын маргаж байгаа үйл баримтыг тогтоохдоо зөвхөн талуудаас гаргаж өгсөн нотлох баримтын хүрээнд хязгаарлагдах бөгөөд шүүх өөрийн санаачилгаар нотлох баримт цуглуулж, шинжлэн судлахыг хориглоно.

Эдгээр гурван ойлголтын үндсэн чиг үүрэг нь, 1 болон 3 дахь ойлголт нь гэнэтийн дайралтаас урьдчилан сэргийлэх замаар нөгөө талдаа мэтгэлцэх боломжийг олгох процессын баталгааны хувиар, 2 дахь ойлголт нь бодит үнэнтэй шүүхийн шийдвэрийг ойртуулах, талууд өөрийн хүсэл зоригоор хийсэн үйлдлийн эсрэг зүйл хэлэхгүй байх, нотлох баримт алга болох, шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг бий болгох зорилготой бөгөөд чиг үүрэгтэй байна. Хуулийн төслийн 338 дугаар зүйл нь мэтгэлцэх зарчмын нэгдүгээр ойлголтыг хуульчлан тусгах замаар мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх зорилготой байна. Өөрөөр хэлбэл шүүх хуралдаан дээр нэг тал өмнө гаргасан тайлбартаа дурдаагүй үйл баримтыг ярих, гаргах нь нөгөө талдаа түүний эсрэг тайлбар бэлдэх, нотлох баримт цуглуулах боломжийг хааж, гэнэтийн дайралт болдог тул мэтгэлцэх зарчим зөрчигдөхөд хүргэх юм. Энэ талаар шүүгч нар дараах байдлаар саналаа хэлж байв:

-Хүлээн зөвшөөрч байна. Яалтачгүй байх ёстой заалт.

-Нэр томёоны хувьд тодорхой болгох шаардлагатай. 337-д өгсөнтэй адил саналтай.

-Амаар тайлбар гаргах эрхийг нээлттэй үлдээх хэрэгтэй. Үндсэн хуульд заасан эрхийг зөрчиж болохгүй. Шүүх хуралдааныг шүүгч өөрөө удирдаж байгаа учраас заавал хатуу хориглох шаардлагагүй. Тайлбарт дурьдсанаас тэс өөр зүйл ярихгүй гэдэг байдлаар нэр томёоллын хувьд арай уян хатан зохицуулалт хийх нь зүйтэй.

Хуулийн төслийн 337 болон 338-ийг хооронд нь нэгтгээд зохицуулбал зохимжтой.

Шүүгч нартай хийсэн ярилцлагаас...

Иймд хуулийн төслийн 338 дугаар зүйл хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй бөгөөд найруулга зүйн хувьд сайжруулах, хуулийн төслийн бусад хэсэгтэй хамтад нь нэг зүйл болгох замаар системчлэлийн уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

3.4. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ хэсэгт хуулийн төслөөс сонгож авсан зохицуулалтыг дагаж мөрдөж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг авч үзэх болно. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн

хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллага болох шүүх, төрийн байгууллагад үүрэг болгосон заалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар санал авч, үйл ажиллагааны тайлан болон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар шалгалаа.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцов. Ингэхдээ дараах хоёр асуултад хариулах байдлаар тус шалгуур үзүүлэлтийг үнэлсэн.

А. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;

Б. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх;

1. Хуулийн төслийн 148-155 дугаар зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг бүрдүүлэх

148 дугаар зүйл.Эсрэг талаас бичмэл нотлох баримт, эд мөрийн баримт гаргуулах
149 дүгээр зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гаргах үүрэг
150 дугаар зүйл.Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөх
151 дүгээр зүйл.Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг албадан гаргуулах
152 дугаар зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөхөөс татгалзах эрх
153 дугаар зүйл.Татгалзах эрхтэй эсэхийг шийдвэрлэх
154 дүгээр зүйл.Хэргийн оролцогч бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөөгүй тохиолдол үүсэх үр дагавар
155 дугаар зүйл.Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөөгүй тохиолдол хүлээх хариуцлага

Хуулийн төслийн 148-155 дугаар зүйлд Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг бүрдүүлэх тухай зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ хэсэгт одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлд заасан агуулгыг тусгасан байна. Харин одоогийн хуульд байхгүй хуулийн төсөлд шинээр орж ирсэн зохицуулалт нь 154 болон 155 дугаар зүйлд заасан хэргийн оролцогч бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөөгүй тохиолдолд үүсэх үр дагавар, түүний хариуцлагийн тухай ойлголт юм.

154 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хэргийн оролцогч нотлох баримт гаргуулах шийдвэрийг биелүүлээгүй бол шүүх тухайн тухайн нотлох баримттай холбоотой эсрэг талын тайлбарыг үнэн гэж үзэж болно” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, шүүгч хэргийн оролцогчоос хэрэг шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөхийг шаардсан боловч гаргаж өгөөгүй бол эсрэг талын тайлбарыг үнэн зөв гэж үзэж болно гэжээ.

Энд хэргийн оролцогч этгээдэд тухайн нотлох баримт байгаа боловч албаар гаргаж өгөхгүй нуун дарагдуулж байгаа тохиолдол, үнэхээр тухайн нотлох баримт байхгүй байгаа тохиолдлыг хооронд нь ялгаж авч үзэх шаардлагатай байна. Энэхүү тохиолдлуудыг ялгаж авч үзэх нь өөр өөр эрх зүйн үр дагаварт хүргэнэ. Ямар ч нотлох баримт гаргаж өгөөгүй байхад хатуугаар эсрэг талын тайлбарыг үнэн зөв гэж шийдэх нь өрөөсгөл ойлголт юм.

Анхнаасаа байхгүй нотлох баримтыг байгаа мэтээр нөгөө талаасаа гаргуулъя гэж шүүгчид албаар өөрийн талд итгэл үнэмшил төрүүлэхээр үнэнд нийцээгүй үйлдэл практикт гарахыг үгүйсгэхгүй билээ. Тиймээс нөгөө талаасаа нотлох баримт гаргуулахаар хүсэлт гаргаж байгаа тал буюу хуулийн төсөлд бичигдсэнээр эсрэг талын гаргаж буй тайлбар, хүсэлт ч мөн адил нотлогдож байх учиртай. Тиймээс энэ заалтыг ямар тохиолдолд ашиглах вэ гэдгийг нарийн тодорхойлох шаардлагатай байна.

Шүүгчдийн үзэж байгаагаар хэргийн оролцогч этгээд тухайн нотлох баримтыг гаргаж өгөөгүй гэх үндэслэлээр шууд эсрэг талын тайлбарыг үнэн гэж үзэхээс илүүтэйгээр тухайн үйл баримт бусад нотлох хэрэгслээр дэмжигдэж байгаа буюу тодорхой хэмжээнд нотлогдож байгаа тохиолдолд л эсрэг талын тайлбарыг үнэн зөв гэж үзэх нь зохимжтой байна. Нарийвчлан тодорхойлоогүйгээс “...эсрэг талын тайлбарыг үнэн гэж үзэж болно” гэсэн нь шүүгчийн дотоод итгэлд нөлөөлөх магадлалтай гэх саналыг мөн шүүгчдээс ирүүлсэн. Угтаа шүүгч аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэн, үнэн бодит үндэслэл бүхий шийдвэр гаргах ёстой боловч энэхүү заалтын дагуу шүүгчийн дотоод итгэл хөндөгдөж болзошгүй нөхцөл байдалд хүрэх эрсдэлтэй байна. Тиймээс дээрх заалтад нотлох үүргийн хуваарилалтын дагуу тухайн үйл баримтыг нотлох үүрэгтэй тал нь нотлох үүргээ биелүүлээгүй бол гэх санааг тодорхой байдлаар тусгах нь зүйтэй.

Мөн 155 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхээс шаардсан бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гаргаж өгөөгүй бол ямар хариуцлага хүлээлгэхийг тодорхой байдлаар оруулах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл үүргээ биелүүлээгүй этгээдэд яг ямар хариуцлага хүлээлгэхийг тодорхойлчихвол заавал Зөрчлийн тухай хуулиар тусад нь шийдэхгүйгээр тухай бүрт нь хариуцлагыг нь хүлээлгэчихвэл энэ заалтын практикт хэрэглэгдэх боломж нь илүү хялбар байх юм.

Түүнчлэн, хуулийн төслийн 152 болон 153 дахь зүйлүүдэд бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөхөөс татгалзах эрхийн талаар тусгасан бөгөөд эдгээр нь агуулга болоод найруулгын хувьд ойлгомжгүй, практикт хэрэгжихэд төдийлөн ач холбогдолгүй заалтууд болжээ. Тухайлбал, 152 дугаар зүйлийн 152.1 дэх хэсэгт тухайн этгээд нь нотлох баримтыг гарган өгөхөөс татгалзах эрхтэй гэж зохицуулжээ. Энэ байдлаар татгалзах эрхийг олгож зохицуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, төвөгтэй байдлыг үүсгэх үр дагавартай байна. Шүүхээс тухайн этгээдэд хандан нотлох баримт гаргаж өгөхийг шаардсан л бол гаргаж өгөх үүрэгтэй гэж байдлаар зохицуулах нь зүйтэй. Хэрэв хүний хувийн болоод албаны нууцтай холбоотой баримт бол нууцын тамга тэмдгээр баталгаажуулаад, хамгаалаад явах нь практикт хэрэгжүүлэхэд хялбар процедур болно.

Мөн хуулийн төсөлд зааснаар тухайн этгээд нотлох баримтыг гарган өгөхөөс татгалзсан тохиолдолд 153 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүгч татгалзах эрхтэй эсэхийг шийдвэрлэнэ. Ингэхдээ шүүгч тухайн этгээдээс нотлох баримтыг гаргуулж авч дангаараа танилцаад татгалзах эрхтэй эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв шүүгч татгалзах эрхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд тухайн нотлох баримт хэрэгт авагдаж шүүхийн

шийдвэрийн үндэслэл болох боломжтой болно. Үүнээс үзэхэд шүүгч тухайн нотлох баримттай дангаараа танилцах ач холбогдол байхгүй болно.

Тиймээс 152 болон 153 дугаар зүйл заалтууд нь төдийлөн ач холбогдолгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах хуулийн төслийн үзэл баримтлалаас эсрэг үр дагавар бүхий заалтууд байна.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; Энэ хуулиар хувийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх тул төслийн зорилтыг “шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэхтэй” гэж тодорхойлоод, хуулийн бусад зохицуулалт энэ зорилтод нийцэж бичигдсэн гэж ойлгож байна. Төслийн 1.1-ийн “шударга, зохистой, хурдан шуурхай, үр нөлөөтэй” гэж орсныг хасах.

2.Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2021 онд батлагдахдаа шүүх эрх мэдлийн зарчим, агуулга, үйл ажиллагааны зохион байгуулалтыг шинээр тодорхойлсон учир энэ хуулийн эх сурвалж болгон заасан нь зөв юм.

3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх; Төсөлд “зохигч” гэсэн нэр томъёог “хэргийн оролцогч” болгон өөрчилсөн. Иймд Прокурорын тухай хуулийн 20.1-д заасан зохигч гэснийг хэргийн оролцогч гэж энэ хуульд нийцүүлэн өөрчлөх. Мөн гуравдагч этгээдийг бие даасан шаардлага гаргасныг “хэргийн оролцогч”-д хамааруулж, шаардлага гаргаагүйг “хэргийн оролцогч” гэж үзээгүй. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн эрх зүйн байдал тодорхойгүй болох учир гуравдагч этгээд шаардлага гаргасан эсэхээс үл хамааран хэргийн оролцогч болох тул зохицуулалтыг нэгтгэж, харин гуравдагч этгээд бие даасан шаардлага гаргасан нь нэхэмжлэгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх агуулгаар зохицуулна.

4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; Төсөлд шинээр болон агуулгыг нь өөрчилсөн зохицуулалтууд дотоод зөрчилгүй, бусад хуультай зөрчилдөөгүй. Харин зарим зохицуулалтын агуулга, найруулгыг засах шаардлагатай.

5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх; Хууль хэмнэлттэй байх зарчмаар бичигдах учиртай. Жишээ нь: тухайн зохицуулалт бүрийн ард уг асуудлаар гомдол гаргах эрхтэй байдлаар бичигдсэн тул ийнхүү заах бус шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхтэй эсэхийг тусгайлан төслийн 317.1-д зааснаар нэгмөр бичих шаардлагатай. Жишээ нь: Одоогийн ИХШХШТХ-ийн 170.1-д тоочин заасантай адил агуулгаар зохицуулалт хийх.

6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;

Шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй тухай одоогийн зохицуулалтыг агуулгаар нь авчээ. Гэтэл шийдвэрийг биелүүлэх явцад шийдвэрт нэр заагдаагүй этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэрийг биелүүлэх, хариуцагчийн үүргийг хүлээх болдог. Хуулийн төслийн 26.1-д “шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүргийг хуулиар хүлээсэн хэн боловч” шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй гэсэн агуулгыг хуульчлах саналтай. Жишээ нь: Хууль тогтоомж өөрчлөгдөх замаар үүрэг хүлээсэн этгээдийн чиг үүрэг нь өөр этгээдэд шилжих, татан буугдах, шинээр зохион байгуулагдах. Мөн эрх болон өв залгамжлалаар өөр этгээд үүрэг хүлээгч болох. Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага хүлээх онцлог харилцаа г.м.

7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх; Цахим нотлох баримт бүрдүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах. Орхигдуулснаас гадна “Гомдлоор авч хэлэлцэх” ХХША-ны зохицуулалтыг илүү гэж үзэх тул хасах.

8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх; Ийм агуулга төсөлд тусгагдаагүй.

9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх; Энэ хууль нь ХХША-нд оролцогчдын харилцааг зохицуулсан тул материаллаг хуулийн шаардах эрх, шаардах эрхээ шилжүүлэхтэй холбоотой агуулгыг энд зохицуулаагүй.

10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; Энэ хуулиар дурдсан харилцааг шинээр бий болгож зохицуулаагүй байна.

11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; Энэ хуулиар зохицуулаагүй. Харин Зөвшөөрлийн тухай хуулийн 11.13-т зааснаар Хуульчдын холбооны олгох “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх” зөвшөөрөлгүй этгээд шүүхэд үйлчлүүлэгчийг төлөөлөн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд шүүх тус этгээдийг ХХША-нд оролцуулахгүй байх эрхтэй байхаар төслийн саналд тусгасан.

12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; Энэ хууль ХХША-г зохистой явуулах харилцааг журамлан зохицуулсан тул хэргийн оролцогчийн эрх, үүргийн зохист байдлыг хангасан гэж ойлгож байна. Жишээ нь, Нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангуулахаар буцаах үед энэ эрхээ хэрэгжүүлээгүй бол нэхэмжлэлээс татгалзах, хариуцагч хуульд заасан хугацаанд тайлбараа гаргаагүй бол хүсэлт, нотлох баримтыг шүүх хүлээн авахгүй байх г.м зохицуулалт нь үндсэн эрхийн хязгаарлалт болохгүй юм.

13.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; Жендэрийн эрх тэгш байх зарчмыг хөндөөгүй гэж үзсэн. Төслийн 8.1-д “бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл”-тэй оролцогч ХХША-нд эрх тэгш, ялгаварлагдахгүй байх зарчимд үйлчилнэ.

14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.

ИХШХШТХ нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг процессын эрх зүйн хэм хэмжээ юм. Харин шударга бус өрсөлдөөнд холбогдох зохицуулалт нь материаллаг эрх зүйн хэм хэмжээтэй түлхүү холбогддог.

Агуулгын хувьд аж ахуй эрхлэгч хэн боловч зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах, маргаанаа шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд тэднийг эрх зүйн статус, төрлөөр ялгаварласан, эрхийг нь дордуулсан шинтэй зохицуулалт төсөлд тусгагдаагүй байна.

15.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын оролцоог тэгш хангах зарчмыг төсөлд бүхэлд нь баримталсан байх ба авлига, хүнд суртал бий болж болзошгүй гэх зохицуулалт ажиглагдаагүй.

16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Талууд хуульд заасан эрх үүргээ биелүүлэхгүй байх нь шүүхээр эрх ашгаа бүрэн хамгаалуулж чадахгүйд хүргэх үг дагавартай байдаг. Үүнийг хуулийн төслийн 249 дүгээр зүйлийн 249.1-д Хэргийн оролцогч хуульд заасан, эсхүл шүүхээс тогтоосон хугацааг хэтрүүлсэн бол хуульд заасан хугацаатай холбоотой эдлэх эрхээ алдана гэж тусгажээ.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг журамласан зохицуулалтыг биелүүлээгүй буюу хугацаа хэтрүүлсэн, баримтаа ирүүлээгүй гэх мэт зөрчлийг энэхүү шалгуурт хамруулж үзээгүй болно.

Харин хуулийн төсөлд шууд хориглосон хэм хэмжээг авч үзэв.

Төслийн 15 дугаар зүйлд хариуцлага оногдуулахад баримтлах зарчмийг тусгасан нь зөрчлийн шинж байдлыг харгалзан үзэх, уян хатан байх, оновчтой, үр нөлөөтэй байх түвшинг дээшлүүлэх ач холбогдолтой.

Төсөлд орчуулагч, хэлмэрчид буруу орчуулга хийх, нотлох баримтыг шүүхэд гаргах, хөндлөнгийн гэрч үүргээ үл биелүүлэх, гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, шинжээч үнэн зөв дүгнэлт гаргах, шүүх хуралдааны оролцогч нар хуралдааны дэг баримтлах, хэргийн оролцогч шүүхийн дуудсан цагт хүрэлцэн ирэхгүй тохиолдод хариуцлага хүлээлгэхээр тусга жээ. Ингэхдээ зөвхөн Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд зааснаар хариуцлага хүлээлгэхээр тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан гэж үзэх үндэслэлтэй.

Шүүхийн тухай хуулийн 50.1.20-д зааснаар шүүгч шүүх хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох үүргээ биелүүлээгүй нь сахилгын зөрчилд тооцогдохоор заасан. Хуулийн төслийн 207-р зүйлд зааснаар шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй байхаар заажээ. Иймд хуулийн төслийн 213-р зүйлд шүүгч дэг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах талаар тусгайлан зохицуулсан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан байх бөгөөд хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага, зорилтыг зарчмын хувьд хангасан байна гэж үзлээ.

4.1. Шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргасан дүгнэлт

А. Зорилгод хүрэх байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хуулийн төслөөр тавьсан зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулан судалсан бөгөөд хуулийн төслийн зохицуулалт нь ерөнхий байдлаар зарчмын хувьд зорилгодоо хүрэх байдлыг хангасан байна. Үүнд зорилгодоо хүрэх байдлыг дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйл. Хариуцлага - Төслийн 19.1 дэх хэсэг нь зорилгодоо хүрэх боломжтой, талуудыг хариуцлагажуулж өгсөн чухал ач холбогдолтой заалт байна. Харин төслийн 19.2 дахь хэсэг нь ойлгомжгүй томъёологдсон байх ба 19.1 дэх хэсэгтэй бүрэн нийцээгүй, түүний ач холбогдлыг бууруулсан шинжтэй тусгагдсан байх тул өөрчлөн найруулж, томъёоллыг сайжруулах шаардлагатай.

Хуулийн төслийн 227-231 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцох - Хуулийн төслийн энэ хэсэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай, үр нөлөөтэй явуулахад зорилгод нийцсэн, хэрэгжих боломжтой заалт гэж дүгнэв. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ИХШХШТХ-ийн зохицуулалтаар тусгай мэдлэг бүхий этгээдийг шинжээч томилох замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оруулж байсан ба тухайн этгээд нь хэрэгт хамааралтай асуудлаар заавал дүгнэлт гаргаж байсан. Зарим тохиолдолд дүгнэлт гаргасан шинжээчийг шүүх хуралдаанд дуудан ирүүлж дүгнэлтийн талаар асуух замаар тусгай мэдээллийг дэлгэрэнгүй тайлбарлуулах боломж бүрддэг байсан. Харин энэхүү хэрэгцээ шаардлагыг хуульд нийцүүлэн тусгасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай явагдах ач холбогдолтой зохицуулалт болжээ.

Хуулийн төслийн 311-316 дугаар зүйл. Шүүхийн урьдчилсан хуралдаан - Хуулийн төслийн энэ хэсгийн зохицуулалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай, үр нөлөөтэй явуулах зорилгод нийцсэн, хэрэгжих боломжтой заалт байна. Урьдчилсан хуралдааныг явуулах нь агуулгын хувьд иргэний процессын эрх зүйн томоохон ахиц, дэвшлийг бий болгох чухал холбогдолтой. Нотлох баримт болон хэргийн үйл баримтыг шүүх хуралдаанаас өмнө бэлтгэх, талуудын идэвхгүй байдлыг зогсоох, шүүх хуралдаан олон удаа хойшилж буй өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж дүгнэв.

Хуулийн төслийн 337 дугаар зүйл. Хариуцагч хариу тайлбар ирүүлэлгүй шүүх хуралдаанд оролцох - Хуулийн төслийн 337.1, 337.2 дугаар зүйл нь зорилгодоо хүрэх боломжгүй, хуулийн төслийн бусад зүйл заалттай зөрчилдсөн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим болох мэтгэлцэх зарчимтай зөрчилдөж байна гэж дүгнэлээ.

Б. Ойлгомжтой байдал

Тус зорилгын хүрээнд хуулийн төсөл ойлгомжтой байдлын шалгуурыг хангасан байна. Гэвч хуулийн төслийн томъёолол, зарим давхардсан шинжтэй зохицуулалтын агуулгыг тодруулах зэрэг нарийвчилсан ажиллагааг нэмж хийх шаардлагатай байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй, үр нөлөөтэй байдлаар удирдан явуулахаар заасан боловч хэт ерөнхий, төслийг аль зохицуулалтад чиглэсэн нь болох нь тодорхойгүй болсон. Иймд энэхүү зарчмын агуулгыг нарийвчлан тодорхойлох, томъёоллыг нягтлан шалгах, хэргийн оролцогчийн эрх үүргийг оновчтой хуваарилах, эрх үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг хэргийн оролцогчийн үйл ажиллагаатай уялдуулах шаардлагатай.

Хуулийн төслийн 76-83 дугаар зүйлд хамтран нэхэмжлэгч, хариуцагчийн талаарх одоогийн ИХШХШТХ-ийн 27 дугаар зүйлийн зохицуулалтыг илүү дэлгэрэнгүй тусгахыг зорьжээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй хамтран оролцох, нэгдэж хамтран оролцох зэрэг шинэ нэр томъёо тусгагдсан боловч тэдгээрийн онцлог, эрх зүйн үр дагавар нь тодорхойгүй, ойлгомжгүй болсон тул дээрх заалтуудын найруулгыг сайжруулах, нэр томъёоны талаарх ойлголтыг тайлбарлах нь зүйтэй.

В. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хуулийн төслийн 11 дүгээр зүйл. Үл маргах зарчим - Хуулийн төсөлд тусгагдсан байдлаар хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй байна. ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйл, Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйл болон энэхүү зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бусад процессын заалтыг төсөлд тусгах замаар тодорхой болгож өгөх шаардлагатай.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч шударгаар оролцох зарчим.- Хуулийн төслийн энэ зохицуулалт хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй, хэрэгжихүйц заалт байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйл. Тохирсон байх зарчим - Хуулийн төслийн 15 дугаар зүйл ойлгомжгүй томъёологдсон, хүлээн зөвшөөрөгдөх байдал султай байна. Иймд хуулийн төслийн 15 дугаар зүйлийг төслийн 13 дугаар зүйлтэй нэгтгэх, уялдуулж тайлбарлах, ямар асуудлаар тохирсон байх буюу уян хатан хандах талаар тодорхой тусгаж өгөх шаардлагатай гэж дүгнэв.

Хуулийн төслийн 17 дугаар зүйл. Тайлбар гаргах үүрэг - Төслийн энэ заалт нь мэтгэлцэх зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чиглэгдсэн, хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй зохицуулалт болсон байна.

Хуулийн төслийн 18 дугаар зүйл. Нотлох үүрэг - Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1-ийн нотлох үүрэг одоо ч агуулгаараа ИХШХШТХ-д тусгагдсан байх бөгөөд хүлээн зөвшөөрөгдөх заалт байна. Хуулийн төслийн 18.2 дахь хэсгийг хүлээн зөвшөөрөгдөхүйц, байх ёстой заалт гэж үзэж байна. Мөн хуулийн төслийн 18.3 дахь хэсэг нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалт байх бөгөөд хуулийн төсөлд шүүгчийн тодруулах эрх болон үүргийг нэмж тусгаж өгвөл хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй гэж дүгнэлээ.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр болон амаар явуулах - Хуулийн төслийн энэ зүйл нь хүлээн зөвшөөрөгдөхүйц, практикт хэрэгжихүйц зохицуулалт байна. Харин хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2-г найруулгын хувьд өөрчлөн найруулах шаардлагатай.

Хуулийн төслийн 251-264 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичиг хүргүүлэх - Хуулийн төслийн энэ хэсгээс 262 дугаар зүйл буюу Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэх, 263 дугаар зүйл Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэх арга, 264 дүгээр зүйл Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэснээр үүсэх үр дагаварыг хүлээн зөвшөөрөх боломжгүй зохицуулалт гэж дүгнэлээ. Энэ талаар тайлангийн холбогдох хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

Хуулийн төслийн 327 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль нэг нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар - Нэгэнт иргэний хэрэг үүсээд, шүүхээс тодорхой ажиллагаа хийсэн, нотлох баримт, тайлбар бүрдсэн, шүүхээс тодорхой зардал гарсан байгаа учраас хэргийг нэг мөр шийдэх нь зүйтэй гэж үзэж байна. Тиймээс хуулийн төслийн 327.1 болон 327.2 дахь хэсэг нь хүлээн зөвшөөрөгдөх заалт байна. Харин 327.3 дахь хэсэг нь өнөөгийн манай нөхцөлд тохиромжгүй учраас практикт хэрэгжих боломжгүй, хүлээн зөвшөөрөх боломжгүй зохицуулалт болсон байна.

Хуулийн төслийн 328 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль аль нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар - Хуулийн төслийн хуулийн төслийн 328 дугаар зүйл хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй ч хуулийн төслийн текстээс “эсхүл шүүх хуралдааныг хойшлуулна” гэсэн агуулгыг хасах нь зүйтэй.

Хуулийн төслийн 329 дүгээр зүйл. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар - Хуулийн төслийн 329 дүгээр зүйл нь бүхэлдээ хүлээн зөвшөөрөгдөх байдалтай байна. Харин төслийн 329.1 болон 329.2-ыг нэгтгэн нэг зүйл болгон өөрчлөн найруулах боломжтой байна.

Хуулийн төслийн 338 дугаар зүйл. Хэргийн оролцогч бичгээр гаргасан тайлбартаа дурдаагүй үйл баримтын талаар шүүх хуралдаанд тайлбар гаргах - Хуулийн төслийн 338 дугаар зүйл хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй бөгөөд найруулга зүйн хувьд сайжруулах, хуулийн төслийн бусад хэсэгтэй хамтад нь нэг зүйл болгох замаар системчлэлийн уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

Г. Практикт хэрэгжих боломж

Энэ шалгуурийн хүрээнд хуулийн төслийн 148-155 дугаар зүйлийг дагаж мөрдөж, практикт хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үзсэн бөгөөд хуулийн төслийг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллага болох шүүх, төрийн байгууллагад үүрэг болгосон заалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар санал авч дүн шинжилгээ хийх замаар шалгалаа.

Хуулийн төслийн 148-155 дугаар зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг бүрдүүлэх - Хуулийн төслийн энэ заалтуудаас 152, 153, 154, 155 дугаар заалтуудыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзлээ. 152 болон 153 дугаар зүйл нь практикт хэрэгжихэд төдийлөн ач холбогдолгүй бөгөөд практикт хэрэгжсэн ч тодорхой үр дагаварт хүргэхгүй учраас тэр чигт нь хуулийн төслөөс хасах нь саналтай байна. Харин 154 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эсрэг талын тайлбар тодорхой хэмжээнд бусад нотлох хэрэгслээр дэмжигдэж байвал гэх зэрэг урьдчилсан нөхцөл тогтоож, илүү нарийвчлан тодорхойлж агуулгын хувьд сайжруулах шаардлагатай байна. 155 дугаар зүйлд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үүргээ биелүүлээгүй этгээд ногдуулах санкцыг тодорхой байдлаар зохицуулах шаардлагатай. Ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэг мөр шийдэхэд түлхэц үзүүлнэ.

Эндээс үзэхэд 148-151 дүгээр заалтууд нь практикт хэрэгжих боломжтой. 154 болон 155 дугаар заалтуудыг агуулгын хувьд нарийн тодорхой байдлаар сайжруулбал практикт хэрэгжих боломжтой. Харин 152, 153 дугаар заалтууд нь хэрэгжих боломжгүй гэж үзлээ.

4.2. Санал, зөвлөмж

Хуулийн төслийн 34, 35-р зүйлд заасан асуудалд зарчмын агуулгыг анхаарч, тухайн шүүх нэгмөр шийдвэрлэж дуусгадаг байх шаардлагатай. Зүй нь эрүүгийн гэмт хэргийн улмаас учирсан мөнгөн хохирлыг тухайн шүүх эрүүгийн хэрэгтэй нь хамт шийдвэрлэж дуусгах бөгөөд нотлох баримт тодорхойгүй, нотлоогүй, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр тусад нь шийдүүлдэг байдал байж болохгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, прокурор, өмгөөлөгч нар энэ байдлаа нотлоогүй бол хэрэгсэхгүй. Мөн ЗХШХШтХ-ийн 106.6-г хасч мөн захиргааны хэргийн шүүх уг асуудлыг дээрх агуулгаар нэгмөр шийдэж дуусгах.

Хуулийн төслийн 103-р зүйлийн төлөөлөн оролцож болохгүй байдалд “Хуульч биш хүн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зорилгоор үйлчлүүлэгчийг шүүхэд төлөөлөх” тохиолдолд шүүгч өөрийн санаачилгаар уг төлөөллийг хүчингүйд тооцох эрхтэй байх. Гаргалгаа нь шүүх эрх, үүрэг тайлбарлахдаа эсхүл урьдчилсан хуралдааны үед энэ асуудлыг талуудад тайлбарласан байх шаардлагатай. Уг асуудлыг Эрүүгийн хуулийн 21.8-д “хохирол учирсан” бол гэмт хэрэгт тооцсон байгаа.

Хуулийн төслийн 219.3.”Шүүх хуралдаанд даргалагч өөрийн саналыг бусад шүүгчдийн дараа гаргана” гэсэн заалтыг төслөөс хасах. Шүүх шийдвэрээ олонхийн саналаар гаргах бөгөөд шүүх бүрэлдэхүүний аль нэг шүүгч давуу эрх эдлэхгүй. Энэ зохицуулалт нь Үндсэн хуулийн 52.1, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 16.1.6, 17.2-т заасантай нийцэхгүй.

Хуулийн төслийн 227-р зүйлд мэргэжилтэн оролцуулах үндэслэлд “зайлшгүй шинжээч томилох шаардлаггүй” гэж нэмэх, мэргэжилтэн нь “тусгай мэдлэг бүхий” буюу мэргэжлийн их, дээд сургууль төгссөн байх, “мэргэшсэн” буюу ажлын арвин туршлагатай байх шалгуурыг нэмж оруулах.

Хуулийн төслийн 251.1-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай баримт бичгийг шүүхийн санаачилгаар хэргийн оролцогчид хүргүүлэх тухай зохицуулалтыг “хүргэхгүй” гэсэн агуулгаар өөрчлөн найруулах. Шүүх хөндлөнгийн этгээд тул бүх баримт бичгийг хүргэхгүй, харин хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн шийдвэрийг, онцгой тохиолдолд л зарим баримт бичгийг хүргэж болно. Харин шүүхийн шийдвэр, бусад баримт бичгийг шүүх хуулийн хугацаанд гаргах, боломжит байдлаар мэдэгдэх, гардан авах нөхцөлийг хангасан байх нь чухал юм.

Хуулийн төслийн 273.1-д заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангах хүрээ нь төслийн 268.1 бус 268 бүхэлдээ байх агуулгаар өөрчлөх. 268.1-с гадна 268.2, 268.3-т заасан үндэслэлээр нэхэмжлэлийг маш их татгалздаг тул энэ зөрчлийг бүрдүүлбэрийг шалгах ажиллагааны явцад засуулах боломжтой.

Хуулийн төслийн 306.1-д заасан нэхэмжлэлээ татан авах хүрээг “гэр бүлийн холбогдолтой, онцгой ажиллагааны журмаар болон гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулахтай холбоотой шаардах эрх”-ээс бусад нэхэмжлэлийг татан авах нь нэхэмжлэлээс татгалзсантай адил үр дагавартай байхаар хумьж зохицуулах шаардлагатай. Нэхэмжлэлээ татан авахад улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

Нэхэмжлэгч шаардах эрхээсээ татгалзлаагүй, харин энэ удаа шүүхээр шийдвэрлүүлэх процессоос татгалзаж байгаа агуулга онолын хувьд байж болох ч практикт сөрөг үр дагавар их гарна. Жишээ нь: нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлээ татан авч улмаар дахин /энэ нь хариуцагчид шахалт үзүүлэх нөлөө, ялангуяа шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг/ дахин гаргах г.м.

Хуулийн төслийн 311.1-д заасан урьдчилсан хуралдаанаар хэлэлцэх асуудалд “нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг тодруулах”, “бусад этгээдийн эрх хөндөгдөх эсэх”-ийг нэмж оруулах. Энэ асуудлаас шалтгаалан ХХША маш их сунжирдаг, дээд шатны шүүхээс хэрэг хүчингүй болох нь их тул урьдчилсан хуралдаанаар тодруулж, нэхэмжлэгчид тодруулсан шаардлага, үндэслэлээ тодорхой хугацаанд шүүхэд гаргахыг даалгах, бусдын эрх хөндөгдсөн нөхцөлд тус этгээдийг ХХША-нд оролцуулах асуудлыг шийдвэрлэх г.м. Хэргийн оролцогч энэ үүргээ биелүүлээгүй бол шүүгч “тодруулах”, “чиглүүлэх” үүргээ /хэргийн оролцогч хүсэлт гаргаагүй ч шүүгч санаачилгаар хэлэлцүүлнэ, энэ үүргээ шүүгч биелүүлээгүй бол зөрчилд тооцно/ биелүүлээгүй гэж үзэхгүй, ХХША-ны зөрчилд тооцохгүй ба хэргийн оролцогчийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, хэрэг хүчингүй болох нь багасах ач холбогдолтой.

Хуулийн төслийн 348-р зүйлд “Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” зарчим орхигдсон байна. Энэ зарчим бол шүүхийн шийдвэрийн амин сүнс тул орхигдуулж болохгүй.

Харин үр нөлөөг тооцох ажиллагааны явцад гарсан дараах асуудлуудыг өөрчлөх, дахин анхаарах шаардлагатай байна гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

А. Зорилгод хүрэх байдал.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйл. Хариуцлага - Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “авахгүй байж болно” гэснийг “авахгүй” гэж өөрчлөх шаардлагатай. Гэвч энэ хэсэгт зайлшгүй анхаарах ёстой асуудал нь шүүх хүлээн авахгүй гэж хатуу байдлаар зохицуулж байгаа учраас шүүхээс тухайн этгээдэд процессын эрхийг нь эдлүүлсэн эсэх, эрхээ эдлэх боломжит хугацаа олгосон эсэхийг сайтар нягталж хуулийн төслийн бусад заалтуудтай хэрхэн холбогдож байгааг анхаарах шаардлагатай. Мөн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хэргийн оролцогч хугацаа хожимдуулсан хүндэтгэн үзэх шалтгаанаа нотолбол гэх агуулгыг тусгах шаардлагатай. Тухайлбал 19 дүгээр зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулж болох юм.

“19.1 Хэргийн оролцогч хууль болон шүүхээс тогтоосон хугацаанд нэмэлт тайлбар, нотлох баримтаа шүүхэд гаргаагүй, эсхүл хугацаа хэтрүүлэн гаргасан тохиолдолд шүүх хүлээн авахгүй.”

“19.2 Хэргийн оролцогч хугацаа хэтрүүлснээ мэдээгүй буюу мэдэх боломжгүй байнаа нотолсон, эсхүл шүүх энэ зүйлд заасан хугацаа тогтоосон талаараа хэргийн оролцогчид мэдэгдээгүй бол хугацаа хэтрүүлсэнд тооцохгүй.”

Хуулийн төслийн 227-231 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтэн оролцох - 227 дугаар зүйлийн гарчиг хэсгийг “Мэргэжилтэн оролцох” бус оролцуулах гэж засах шаардлагатай. Мэргэжилтэн оролцуулах тухай ойлголт нь хэргийг түргэн шуурхай шийдвэрлэхэд ач холбогдолтой хэдий ч маргааны үйл баримтыг үнэн зөв

тогтоох нь түүнээс илүү ач холбогдолтой учраас дарааллын хувьд дараах байдлаар өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзлээ.

“227.1 Маргаантай үйл баримтын талаар зайлшгүй шинжээч томилох шаардлагагүй, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах зорилгоор тухайн асуудлаар мэргэшсэн, тусгай мэдлэг бүхий этгээдийг хэргийн оролцогчийн хүсэлт болон шүүхийн санаачлагаар оролцуулж, тусгай мэдлэгт тулгуурласан тайлбарыг сонсож болно.”

“227.3 Шүүх шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогчийн хүсэлтээр нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулж, уг нотлох баримтын талаар тайлбарлуулж болно.”

Мөн хуулийн төслийн бүтцийн хувьд тодорхой бөгөөд ойлгомжтой байх үүднээс тухайн шат бүрт тохирсон заалт оруулах шаардлагагүй. Тухайлбал мэргэжилтнийг томилох хөлс төлөхтэй холбоотой ажиллагаа нь шинжээч, гэрч, орчуулагч, хэлмэрч зэргийг томилохтой адил журмаар зохицуулагдах боломжтой тул дараах байдлаар товч бөгөөд тодорхой зохицуулж, хуулийн төслийн 228, 229, 230, 231 дүгээр зүйлүүдийг хасах нь зүйтэй.

“227.4.Мэргэжилтэн шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжгүй нөхцөлд энэ хуулийн ...-д заасан журмын дагуу оролцуулна.”

“227.5.Мэргэжилтнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд томилж оролцуулахад шинжээч томилохтой холбоотой журам нэгэн адил үйлчилнэ.”

Хуулийн төслийн 311-316 дугаар зүйл. Шүүхийн урьдчилсан хуралдаан - Хуулийн төслийн 312 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “хэд хэдэн удаа” гэснийг “нэг удаа, шаардлагатай тохиолдолд хоёр удаа” гэх байдлаар өөрчлөх шаардлагатай. Мөн 315.1.2-т шинжлэн судлах гэсний оронд маргаантай үйл баримтад хамааралтай нотлох баримтыг талуудад танилцуулах гэх байдлаар үг үсгийн найруулга хийх шаардлагатай. Мөн 316 дугаар зүйлд шүүгч урьдчилсан хуралдааныг хааж ямар эрхийн акт гаргах тухай тодорхой зохицуулах шаардлагатай. 316 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хэргийг агуулгаар нь гэдгийн оронд хууль зүйн асуудлаар хэлэлцэхгүй гэх байдлаар тодорхой тусгах нь зүйтэй.

Хуулийн төслийн 337 дугаар зүйл. Хариуцагч хариу тайлбар ирүүлэлгүй шүүх хуралдаанд оролцох.- Энэхүү заалт нь мэтгэлцэх зарчимтай зөрчилдөж байгаа учраас бүхэлд нь хасах, эсхүл бусад зүйл заалтын агуулгатай нийцүүлэн өөрчлөн найруулах шаардлагатай.

Б. Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн 13 дугаар зүйл. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах зарчим.- “идэвхитэй, үр нөлөөтэй” гэдгийг шүүгч хөндлөнгийн байх зарчимтай зөрчилдөхгүй байдлаар томьёолж, оруулах.

Хуулийн төслийн 76-83 дугаар зүйл. Хамтран нэхэмжлэгч, хариуцагч.- Бүхэлд нь дахин найруулах, ойлгомжтой болгох. Хамтран нэхэмжлэгч, хэд хэдэн нэхэмжлэгч, хамтран хариуцагч, хэд хэдэн хариуцагчийг ялгамжтай байдлаар томьёолох.

В. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хуулийн төслийн 11 дүгээр зүйл. Үл маргах зарчим - Хуулийн төслөөс хасах. Нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулах заалтыг боловсронгуй болгох.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч шударгаар оролцох зарчим - Хэргийн оролцогч гэсний араас “өмгөөлөгч”-ийг мөн нэмж өгөх, энэ зүйлийн гарчгийг “Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэнч, шударгаар оролцох зарчим” гэж өөрчлөх.

Хуулийн төслийн 15 дугаар зүйл. Тохирсон байх зарчим - “Тохирсон байх” гэдгийг “Уян хатан байх” гэдгээр сольж болох эсэх, илүү оновчтой томьёолол, найруулга хэрэглэх. Төслийн 15.2-т “хэргийн нарийн төвөгтэй байдал, ач холбогдол, шинж чанар” гэснийг “хэргийн нөхцөл байдал, ээдрээ төвөгтэй байдал зэргээр” тогтсон нэр томьёогоор өөрчлөн найруулах. “Харьцангуй байдал” гэсэн нэр томьёог “ялгамжтай байх” зэргээр илүү ойлгомжтой нэр томьёо ашиглах. Энэ заалтын гарчгийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэргийн нөхцөл байдалд тохирсон байх зарчим” гэж өөрчилж болох юм. Төслийн 15.3, 15.4 дэх заалт нь энэ хэсэгт байх нь зохимжтой эсэхийг шийдвэрлэх, системчлэлийн уялдаа холбоог хангах.

Хуулийн төслийн 17 дугаар зүйл. Тайлбар гаргах үүрэг - Хуулийн төслийн 17.1 дэх хэсэгт “бичгээр тайлбар гаргах үүрэгтэй” гэж өөрчлөн найруулах.

Хуулийн төслийн 18 дугаар зүйл. Нотлох үүрэг - Хуулийн төслийн 18.3-г оруулж байгаа бол шүүгчийн тодруулах эрх болон үүргийн талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж өгөх.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр болон амаар явуулах - Хуулийн төслийн 21.2 дахь хэсгийн “амаар” гэдгийг хасах. Нэгэнт бичгээр явуулахаар болж байгаа бол бүх зүйлийг бичгээр баримтжуулсан байхыг шаардах.

Хуулийн төслийн 251-264 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичиг хүргүүлэх - Хуулийн төслийн энэ хэсгээс нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхтэй холбоотой хэсгийг хасах.

Хуулийн төслийн 327 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль нэг нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар - Хуулийн төслөөс 327.3 дахь хэсгийг хасах.

Хуулийн төслийн 328 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн аль аль нь шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар - Хуулийн төслийн 328.1 дэх хэсгээс “хойшлуулах” гэдгийг хасах.

Хуулийн төслийн 329 дүгээр зүйл. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар - Хуулийн төслийн 329.1 болон 329.2-ийг нэгтгэн томьёолох, мөн “хойшлуулах боломжгүй бол” гэдгийг ойлгомжтой байдлаар найруулах.

Г. Практикт хэрэгжих боломж.

Хуулийн төслийн 148-155 дугаар зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг бүрдүүлэх- Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөхөөс татгалзах эрхийн тухай 152, 153 дугаар зүйл заалт нь практикт хэрэгжихэд ач холбогдолгүй учраас бүхэлд нь хасах нь зүйтэй. Харин 154 дүгээр зүйлд эсрэг талын тайлбар нь бусад нотлох хэрэгслээр дэмжигдэж, тодорхой хэмжээнд нотлогдож байх тохиодолд үнэн гэж үзэх байдлаар тодорхой урьдчилсан нөхцлийг тусгай шаардлагатай. Мөн 154 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт

баримт бичгийг устгасан, ашиглах боломжгүй болгосон гэдгийг хэрхэн тогтоох тухай тодорхойлох нь зүйтэй. 155 дугаар зүйлд “зохих хууль тогтоомжид заасан хариуцлага” гэсний оронд яг ямар хариуцлага хүлээлгэхийг тодорхой зохицуулах шаардлагатай.

Хуулийн төслийг бүхэлд нь уншиж үзээд найруулга, нэр томьёо, нэмж тусгах шаардлагатай зохицуулалтын талаар саналаа гаргасан болно. Эдгээр саналыг хавсралт 1-ээс харна уу.

---oOo---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992/;
2. Хууль тогтоомжийн тухай хууль /2015 он/;
3. Иргэний хууль;
4. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
5. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
6. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”;

Б. Бусад

1. Нямдоогийн Баярмаа ИРГЭНИЙ ХЭРГИЙН ОНЦЛОГТ ТУЛГУУРЛАН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ ШААРДЛАГА (2023) <https://legaldata.mn/buteel/pdf?id=1659>
2. Алтангэрэлийн Доржсүрэн ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТИЙН АЧ ХОЛБОГДОЛ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ (2023) <https://legaldata.mn/buteel/pdf?id=1531>
3. Батсайханы Наранцэцэг Бэгзжавын Уянга Энхбаатарын Энхцэцэг Баяраагийн Баялагмаа ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ: НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ЗАХИРАМЖИЙН ЖИШЭЭН ДЭЭР (2023) <https://legaldata.mn/buteel/pdf?id=1480>
4. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 106 ДУГААР ЗҮЙЛИЙН 106.3, 106.5 ДАХЬ ХЭСГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА (2022) <https://legaldata.mn/buteel/pdf?id=1386>
5. Мөнхбаярын Цэдэнпунцаг АРБИТРЫН ХЭЛЭЛЦЭЭР БА ХЭРГИЙН ХАРЬЯАЛЛЫН ЗАРИМ АСУУДАЛ (2021) <https://legaldata.mn/buteel/pdf?id=1343>
6. Энхжаргалын Мөнхдаваа ХЭРГЭЭ ШҮҮХ АЖИЛЛАГААНД БИЕЭР ОРОЛЦОХ ЭРХ (2019) <https://legaldata.mn/buteel/pdf?id=1254>
7. Төмөрбаатарын Бадрах CLASS ACTION ЗОХИЦУУЛАЛТ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА (2021) <https://legaldata.mn/buteel/pdf?id=1168>

8. Төмөрбаатарын Бадрах ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ (2019) <https://legaldata.mn/buteel/pdf?id=942>
9. Удвалын Азжаргал ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЗАРЧМЫН ШИЙДЭЛ /ИХШХШТХ105.2/ (2019) <https://legaldata.mn/buteel/pdf?id=889>
10. Бат-Эрдэнийн Буянхишиг Э.Отгонзул, Б.Цэнгүүн, Б.Цэвээндэмбэрэл, Б.Хулан, Э.Гэрэл, У.Азжаргал ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА: ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ БА ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХОЙШЛОЛТ (2019) <https://legaldata.mn/buteel/pdf?id=827>
11. Б.Хишигбаатар ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ, ҮР НӨЛӨӨ (2019) ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ 2019/№2 <https://legaldata.mn/buteel/pdf?id=749>
12. Т.Наранцогт ИХШХШТХ-ийн зарим зохицуулалтын хэрэгжилт, үр нөлөөг эрх зүйн социологийн үүднээс авч үзэх нь (2018) ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ 2018/№2 <https://legaldata.mn/buteel/pdf?id=745>
13. Б.Хонгорзул Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэх нь (2018) ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ 2018/№2 <https://legaldata.mn/buteel/pdf?id=745>
14. Дамбын Ганхүрэл ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХ ШҮҮГЧИЙН ТОДРУУЛАХ ЭРХ БА МЭТГЭЛЦЭХ ЗАРЧИМ (2017) <https://legaldata.mn/buteel/pdf?id=284>

ХАВСРАЛТ 1. Хуулийн төслийг бүхэлд нь уншаад өгсөн санал

ХАВСРАЛТ 2. Шүүгч нартай хийсэн ярилцлага